

Байгаль орчинд нөлөөлөх  
байдлын үнэлгээнд олон  
нийтийн оролцоог хангах  
журам, түүний хэрэгжилтэд  
хийсэн дүн шинжилгээ

Энэхүү тайланг Байгаль орчин аялал жуулчлалын яамнаас тавьсан хүсэлтийн дагуу Австрали-Монголын эрдэс баялгийн салбарын хамтын ажиллагааны хөтөлбөрийн (АМЕП2) хүрээнд боловсруулсан бөгөөд АМЕП 2 хөтөлбөрийг Австрали Улсын Гадаад харилцаа худалдааны яам санхүүжүүлэн, Адам смит Интернэйшнл компани хэрэгжүүлэн ажиллаж байна.

\* \* \*

\* \* \*

\* \* \*

\* \* \*

\* \* \*

**Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах журам, түүний хэрэгжилтэд хийсэн дүн шинжилгээ**

Энэ судалгааны тайланг “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор 2014 онд батлагдсан БОНБҮ-нд олон нийтийн оролцоог хангах тухай журмыг боловсронгуй болгох төслийн хүрээнд боловсруулав.

Дүн шинжилгээг хийж, тайланг боловсруулсан: АМЕП-2 төслийн олон нийтийн оролцооны зөвлөх Доктор Д.Бямбажав

2021 оны 6 сарын 15

## Гарчиг

|  |    |
|--|----|
| 1. Оршил .....   | 4  |
| 2. БОНБУ-нд олон нийтийн оролцоог хангах шаардлага, зарчим.....                              | 4  |
| 3. Журмын зүйл, заалтын шинжилгээ .....  | 6  |
| 3.3 Хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний явцад олон нийтийн оролцоог хангах тухай.....         | 9  |
| 3.4 Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээний явцад олон нийтийн оролцоог хангах .....     | 11 |
| 3.5 Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний явцад олон нийтийн оролцоог хангах..... | 12 |
| 3.6 Үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах ажлын санхүүжилт.....                             | 15 |
| 3.7 Гомдол маргаан шийдвэрлэх.....   | 16 |
| 4. Журмын хэрэгжилтийн үнэлгээ .....   | 17 |
| 5. Дүгнэлт, зөвлөмж.....   | 20 |
| 6. Холбогдох эрх зүйн баримт бичиг .....   | 21 |
| 7. Хавсралт .....  | 23 |

## 1. Оршил

2014 онд батлагдсан БОНБУ-нд олон нийтийн оролцоог хангах журмын зохицуулалтын хамрах хүрээ, зүйл, заалтуудын ойлгомжтой байдал, харилцан уялдаа, давхардал, хийдлийг үнэлэх зорилгоор энэ дүн шинжилгээг хийлээ.

Дүн шинжилгээг хийхдээ БОНБУ-нд олон нийтийн оролцоог хангахад баримтлах суурь зарчмууд, Монгол улсын холбогдох хууль, журмын зохицуулалт, ялангуяа 2014 оноос хойш шинээр батлагдсан болон шинэчилсэн хууль, журамтай хэрхэн уялдаж буйг харгалзан үзсэн.

Түүнчлэн, энэ төслийн хүрээнд хийсэн оролцогч талуудын судалгаа, ИНХ-ын тогтоол, хуралдааны тэмдэглэлд хийсэн дүн шинжилгээнд үндэслэн журмын хэрэгжилтийг үнэлж, тулгамдаж буй асуудлуудыг тодорхойлов.

Дүн шинжилгээг хийхдээ Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”, “Хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийх аргачлал”, “Хууль тогтоомжийн хэрэгцээ шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал”-ыг ашигласан болно.

## 2. БОНБУ-нд олон нийтийн оролцоог хангах шаардлага, зарчим

БОНБУ-нд олон нийтийн оролцоог хангах нь хүний эрхийн хэрэгжилтийг хангах, мэдээлэл цуглуулж, оновчтой, үр дүнтэй шийдвэр гаргах, талуудын хооронд зөв ойлголцол бий болгох, хөтөлбөр, төслийн хэрэгжилтийг хангах ач холбогдолтой гэдгийг олон улсын болон Монгол улсын холбогдох бодлогын баримт бичиг, эрх зүйн эх сурвалжуудад хүлээн зөвшөөрсөн байдаг. НҮБ-ын “Хүний эрх ба байгаль орчны удирдах зарчмууд” баримт бичигт БОНБУ-нд олон нийтийн оролцоог үнэлгээний эхнээс тууштай хангах, олон нийтийг мэдээллээр хангаж, саналаа илэрхийлэх боломж олгох, олон нийтийн саналыг шийдвэр гаргахдаа харгалзах, шийдвэр нь олон нийтэд ойлгомжтой, ил тод байх нь хүн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхээ эдлэх чухал механизм гэж үзсэн байна.<sup>1</sup> Бизнесийн болон хөгжлийн томоохон төслүүдийн санхүүжилт олгодог Дэлхийн банк, Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк, Азийн Хөгжлийн Банк зэрэг олон улсын томоохон байгууллагууд хөтөлбөр, төслийн БОНБУ-нд олон нийтийн оролцоог хангах удирдамжийг тус бүртээ боловсруулсан байдаг. Дэлхийн банкны хувьд 1989 онд анх олон нийтийн оролцоог хангах асуудлыг өөрийн БОНБУ-ний талаар баримтлах бодлогод тусгасан байдаг. Ингэхдээ үнэлгээний таамаглах үе шатанд олон нийтэд төслийн талаар болон таамаглаж буй нөлөөллийн талаар мэдээлэл өгч санал авах,

---

<sup>1</sup> Office of the High Commissioner for Human Rights. Framework Principles on Human Rights and the Environment. 2018.  
<https://www.ohchr.org/Documents/Issues/Environment/SREnvironment/FrameworkPrinciplesUserFriendlyVersion.pdf>

БОНБУ-ний тайлангийн төслийг боловсруулж дууссаны дараа олон нийтэд мэдээлэл өгч санал авах үндсэн шаардлага тавьсан байдаг. Сүүлийн 20 орчим жилд дээрх байгууллагууд БОНБУ-нд олон нийтийн оролцоог хангах удирдамж, шаардлагаа улам нарийвчилж, нийтлэг жишиг бий болгосон.<sup>2</sup>

Монгол Улсын Их Хурал 1998 оны 1 сард БОНБУ-ний тухай хуулийг анх батлахдаа олон нийтийн оролцоог хангах зохицуулалтыг оруулсан. Энэ хуулиар үнэлгээний тайланд тусгах асуудлын жагсаалтад “төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн иргэдийн санал” (5.4.8) байна гэж заасан. 2001 оны 11 сард энэ хуульд оруулсан өөрчлөлтөөр уг заалтыг “төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн иргэд, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчдийн санал” болгон өөрчилсөн. Түүнчлэн уг хуульд анх “Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нарийвчилсан үнэлгээний тайланд хийсэн шинжээчийн дүгнэлтийг үндэслэн төслийг хэрэгжүүлэх эсэх асуудлыг шийдвэрлэнэ” (7.3) гэж заасан байсныг “Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нарийвчилсан үнэлгээний тайланд хийсэн шинжээчийн дүгнэлтийг үндэслэн, тухайн төсөл хэрэгжих газрын иргэдийн саналыг харгалзан төслийг хэрэгжүүлэх эсэх асуудлыг шийдвэрлэнэ” гэсэн чухал өөрчлөлтийг оруулж байсан байна. 2012 онд БОНБУ-ний тухай хуулийг шинэчлэн батлах нэг гол зорилт нь олон нийт, иргэдийг оролцоог хангах зохицуулалтыг боловсронгуй болгох явдал байсан бөгөөд “Нөлөөллийн үнэлгээний үйл ажиллагааны олон нийтийн оролцоо” гэдэг тусгай зүйл, бусад холбогдох заалтыг нэмж оруулсан. БОНБУ-ний тухай хуулийн 18.5-д “Олон нийтийн оролцооны асуудлыг журмаар зохицуулах бөгөөд уг журмыг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална” гэж заасны дагуу Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны 1 сарын 6-ны өдрийн А-03 тоот тушаалаар “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах тухай журам” батлагдсан.

Журамд олон нийтийн оролцоог хангах үйл ажиллагаанд баримтлах зарчмуудыг тодорхойлсон. Үүнд:

- 1.2.1.мэдээллийг түгээж, ил тод хүртээмжтэй байлгах;
- 1.2.2.хөгжлийн бодлого, хөтөлбөр, төлөвлөгөө, түүнийг санаачлан боловсруулагч салбарын яам, төсөл хэрэгжүүлэгч болон нөлөөлөлд өртөж болзошгүй иргэд /”Нөлөөлөлд өртөж болзошгүй иргэд” гэж төслийн нөлөөлөлд шууд ба шууд бус хэлбэрээр өртсөн болон өртөж болзошгүй тухайн төсөл хэрэгжиж буй нутгийн иргэд, орон нутгийн болон холбогдох бусад байгууллагын төлөөлөл багтсан өргөн хүрээтэй ойлголтыг хэлнэ/ хоорондын мэдээлэл солилцох, зөвлөлдөх, зөвшилцөх боломжийг хангах;
- 1.2.3.төслийн учирч болзошгүй нөлөөллөөс урьдчилан сэргийлж, түүнийг бууруулах, арилгах арга хэмжээ, хянах тогтолцоог бүрдүүлэхэд шинжлэх ухааны загвар, тоон мэдээллийг оролцогч талуудын санал бодолтой хослуулах;

---

<sup>2</sup> Тухайлбал Европын сэргээн босголт хөгжлийн банкны А ангиллын төслийн Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээнд тавигдах шаардлага, Дэлхийн банкны Олон нийтийн хэлэлцүүлэг, мэдээллийн нээлттэй байдлын журам, Олон улсын санхүүгийн корпорацын Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээний менежментийн стандартыг дурдаж болно.

- 1.2.4. оролцогч талууд үнэлгээний үйл явцад хариуцлагатай хандах;
- 1.2.5. орон нутгийн иргэдийн уламжлалт соёл, зан заншил, үнэт зүйл, амьдралын уламжлалт хэвшил, эрхийг хүндэтгэх.

Эдгээр нь Олон улсын нөлөөллийн үнэлгээний холбооны зөвлөмжийн БОНБҮ хийхэд баримтлах орон нутгийн онцлогт тохирсон байх, олон нийтийг мэдээллээр хангах, хүн амын бүлгүүдийн ялгааг харгалзах, зөвлөлдөх, харилцан ойлголцох суурь зарчмуудтай нийцэж байна.<sup>3</sup> Уг зөвлөмжид суурь зарчмуудаас гадна оролцоог хангах үйл ажиллагааг хэрэгжүүлэх шатанд баримтлах зарчмуудыг тодорхойлсон байдаг. Үүнд:

- Оролцоог хангах ажлыг аль болох эрт эхлүүлж, тууштай хэрэгжүүлэх
- Оролцоог хангах үйл ажиллагааг сайтар төлөвлөж, зөвлөлдөх асуудалд анхаарах
- Олон нийтийн оролцоог мэдээлэл өгөх, сургалт хийх, оролцох таатай нөхцөл бүрдүүлж дэмжих
- Олон нийт мэдээлэлтэй танилцах шаардлагатай хугацаа, оролцоход тохиромжтой хэлбэр, орчноор хангах
- Оролцоог хангах үйл ажиллагаа нөлөөлөлд өртөгч болон сонирхож буй бүх талуудад нээлттэй, ил тод байх
- Орон нутгийн засаг захиргааны зохион байгуулалт, уламжлалт соёл, зан заншил, хэвшилд тохирсон уян хатан байх
- Оролцоог хангах үйл ажиллагаанд хуулийн болон ёс суртахууны хэм хэмжээг баримтлах

### 3. Журмын зүйл, заалтын шинжилгээ

Уг журмын зохицуулалт нь дараах үндсэн асуудлуудыг хамарсан байна. Үүнд:

- Мэдээллийн ил тод байдлыг хангах тухай /1.4-1.5/
- Стратегийн үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах тухай /2.1.1-2.1.3/
- Хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний явцад олон нийтийн оролцоог хангах тухай /2.2.1-2.2.4, 2.3/
- Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээний явцад олон нийтийн оролцоог хангах /2.4.1-2.4.2/
- Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний явцад олон нийтийн оролцоог хангах /2.5-2.12/
- Үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах ажлын санхүүжилт /3.1-3.3/
- Гомдол маргаан шийдвэрлэх /3.5-3.7/

Эдгээр зүйл, заалт тус бүрийг дараах шалгуурын дагуу авч үзсэн.

| Шалгуур           | Шалгах хэрэгсэл  |
|-------------------|--|
| Ойлгомжтой байдал | - Зүйл, заалтыг нэг мөр ойлгож, хэрэгжүүлэх боломжтой эсэх |

<sup>3</sup> André, P., B. Enserink, D. Connor and P. Croal 2006 Public Participation International Best Practice Principles. Special Publication Series No. 4. Fargo, USA: International Association for Impact Assessment.

|                 |  |
|-----------------|--|
| Харилцан уялдаа | <ul style="list-style-type: none"> <li>- Зүйл, заалтын нэр томьёо холбогдох хууль, журмын нэр томьёотой нийцэж байгаа эсэх;</li> <li>- Зүйл, заалт нь холбогдох хууль, журмын заалттай нийцэж байгаа эсэх;</li> <li>- Зүйл, заалтад хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх;</li> <li>- Зүйл заалтад шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх;</li> <li>- Зүйл заалтад холбогдох байгууллагуудын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх;</li> </ul> |
|-----------------|--|

### 3.1 Мэдээллийн ил тод байдлыг хангах тухай

Журамд мэдээллийн ил тод байдлыг хангах талаар дараах 3 заалт байна. Үүнд:

1.3.Аливаа төсөл, хөгжлийн бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөний байгаль орчин, хүний эрүүл мэндэд аюул учруулж болзошгүй мэдээлэл нийтэд нээлттэй байх ба иргэд, олон нийт бодлого, хөтөлбөр, төлөвлөгөө, төслийн талаарх мэдээлэл олж авах нөхцөлөөр хангагдсан байна.

1.4.Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон орон нутгийн байгууллага нь олон нийтийн оролцоог хангахад шаардагдах бодлогын баримт бичиг, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай холбогдох журам, заавар, аргачлалыг иргэд, олон нийтэд нээлттэй байлгана.

1.5.Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь стратегийн үнэлгээ хийгдсэн хөгжлийн бодлого, хөтөлбөр, төлөвлөгөө болон байгаль орчны нөлөөллийн үнэлгээнд хамрагдсан төслүүдийн талаарх, аймаг, нийслэлийн байгаль орчны алба нь байгаль орчны нөлөөллийн үнэлгээнд хамрагдсан төслүүдийн талаарх мэдээллийг цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэх ажлыг зохион байгуулна. Менежментийн төлөвлөгөөг олон нийтэд нээлттэй байлгана.

Эдгээрийг үндсэн шалгуурын дагуу үнэлж, анхаарах асуудлуудыг тодорхойлов.

| Шалгуур                 | Тайлбар   | Санал   |
|-------------------------|---|---|
| Ойлгомжгүй байгаа хэсэг | <ul style="list-style-type: none"> <li>- 1.3 заалт нь “аюул учруулж болзошгүй мэдээлэл нийтэд нээлттэй байх” гэсэн найруулгын алдаатай байна.</li> <li>- 1.3 заалтын сөрөг нөлөөллийн тухай мэдээлэл нийтэд нээлттэй байх зохицуулалт нь хэт ерөнхий, нэг мөр ойлгоход бэрхшээлтэй байна.</li> <li>- 1.3 заалтын мэдээлэл олж авах нөхцөлөөр хангагдсан байх зохицуулалт хэт ерөнхий, нэг мөр ойлгоход бэрхшээлтэй байна.</li> <li>- 1.4 заалтын “олон нийтийн оролцоог хангахад шаардагдах бодлогын баримт бичиг” гэдэгт юуг ойлгох нь тодорхой бус байна.</li> <li>- 1.5 заалтын “төслүүдийн талаарх мэдээлэл” гэдэгт юуг оруулах нь ойлгомжгүй байна.</li> </ul> | <ul style="list-style-type: none"> <li>- Найруулгыг засах</li> <li>- Монгол улсын Үндсэн хуулийн 6-р зүйл, Мэдээллийн ил тод байдал, мэдээлэл авах эрхийн тухай хуульд нийцүүлэх</li> <li>- Мэдээллийн ил тод байдал, мэдээлэл авах эрхийн тухай хуульд нийцүүлэн мэдээллийг ямар хэлбэрээр, хаана байрлуулах тухай тусгах</li> <li>- Төслүүдийн хураангуй, тайлангийн төсөл бүрэн эхээрээ, батлагдсан тайлан гэх мэтээр ямар мэдээллийг цахимаар байрлуулахыг тодорхой тусгах</li> </ul> |

|                               |   |   |
|-------------------------------|---|---|
|                               | <ul style="list-style-type: none"> <li>- 1.5 заалтын “Менежментийн төлөвлөгөөг олон нийтэд нээлттэй байлгана” гэж заасан нь БОАЖЯ, байгаль орчны албаны үүрэг эсэх нь нэг мөр ойлгомжгүй.</li> </ul>  |   |
| Уялдаа холбоог анхаарах хэсэг | <ul style="list-style-type: none"> <li>- 1.3 заалтад “байгаль орчин, хүний эрүүл мэндэд аюул учруулж болзошгүй” гэдэг БОНБУ-ний тухай хуульд тусгагдаагүй, тодорхой бус нэр томьёо хэрэглэсэн байна.</li> <li>- 1.5 заалтад байгаль орчны нөлөөллийн үнэлгээнд хамрагдсан төслүүдийн талаар мэдээлэх БОАЖЯ, аймаг, нийслэлийн байгаль орчны албаны чиг үүргийг давхардуулсан байна.</li> <li>- Сум, дүүрэг, баг, хорооны олон нийтэд мэдээлэл өгөх чиг үүргийг орхигдуулсан байна.</li> </ul> | <ul style="list-style-type: none"> <li>- Хуулийн заалт, нэр томьёонд нийцүүлэх</li> <li>- БОАЖЯ, аймаг, нийслэлийн байгаль орчны албаны чиг үүргийг зааглах</li> <li>- 2022 оны 1 сараас мөрдөгдөх Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн тухай шинэ хуульд нийцүүлэн сум, дүүрэг, баг, хорооны чиг үүргийг тусгах</li> </ul> |

### 3.2 Стратегийн үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах тухай

Журамд стратегийн үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах тухай дараах 3 заалт байна. Үүнд:

2.1. Байгаль орчны стратегийн үнэлгээний явцад олон нийтийн оролцоог дараах байдлаар хангана:

2.1.1. стратегийн үнэлгээ хийх мэргэжлийн баг нь үнэлгээний үйл ажиллагаанд олон нийтээс санал авах тухай мэдээллийг санал авч эхлэхээс өмнө олон нийтэд мэдээлж, ажлын 21 хоногт багтаан санал авах;

2.1.2. стратегийн үнэлгээ хийх явцад гарч байгаа урьдчилсан дүгнэлт, зөвлөмжийн талаарх олон нийтийн нээлттэй хэлэлцүүлгийг хөгжлийн бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөг санаачлан боловсруулагч салбарын яам нь стратеги үнэлгээ хийх мэргэжлийн багтай хамтран зохион байгуулах;

2.1.3. стратегийн үнэлгээ хийх мэргэжлийн баг нь олон нийтээс санал авч, хэлэлцүүлэг зохион байгуулсан арга хэлбэр, гарсан санал, шүүмжийг хэрхэн тусгасан талаар тайланд тусгах.

БОНБУ-ний хуулийн 5.1-д зааснаар бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөг санаачлан боловсруулагч салбарын яам нь уг баримт бичгийг боловсруулах явцад стратегийн үнэлгээ хийлгэж, Засгийн газарт хэлэлцүүлэхээс өмнө уг үнэлгээний тайланг бодлогын баримт бичгийн төслийн хамт БОАЖЯ-нд ирүүлж, мэргэжлийн зөвлөлөөр дүгнэлт гаргуулах ёстой. Гэвч монгол улсад одоог хүртэл нэг ч стратегийн үнэлгээ хийгдээгүй байгаа гэдгийг дурдах нь зүйтэй.

Журмын зохицуулалтыг үндсэн шалгуурын дагуу үнэлж, анхаарах асуудлуудыг тодорхойлов.

| Шалгуур                 | Тайлбар   | Санал   |
|-------------------------|---|---|
| Ойлгомжгүй байгаа хэсэг | - 2.1.1 заалтад “олон нийтээс санал авах тухай мэдээллийг санал авч эхлэхээс өмнө олон нийтэд мэдээлж” гэж заасан | - Үнэлгээний аль үе шатуудад санал авах тухай тодорхой тусгах<br>- Хууль тогтоомжийн тухай хуулийн 38.6-р заалтад зохицуулсан жишгээр |



|                               |   |   |
|-------------------------------|---|---|
|                               | <p>үнэлгээний таамаглах эхэн үе үү, тайлангийн төслийн боловсруулж дууссаны дараа юу гэдэг нь ойлгомжгүй байна.</p> <ul style="list-style-type: none"> <li>- 2.1.3-р заалтад “санал авч, хэлэлцүүлэг зохион байгуулсан арга хэлбэр, гарсан санал, шүүмжийг хэрхэн тусгасан талаар тайланд тусгах” гэж заасан нь хэт ерөнхий байна.</li> </ul> | <p>“олон нийтийн хэлэлцүүлгийн хугацаа дууссан өдрөөс хойш 30 хоногийн дотор төсөлд тусгасан болон тусгаагүй саналын товъёгийг бэлтгэн албан ёсны цахим хуудсандаа байршуулна” гэж оруулах.</p>   |
| Уялдаа холбоог анхаарах хэсэг | <ul style="list-style-type: none"> <li>- 2.1.1-р заалтад олон нийтээс ямар арга, хэлбэрээр санал авах тухай зохицуулалтыг орхигдуулсан байна.</li> <li>- 2.1.2 заалтад олон нийтийн нээлттэй хэлэлцүүлгийг зохион байгуулах талаар олон нийтэд мэдээлэх хугацаа, арга хэлбэр, давтамжийг зохицуулалгүй орхигдуулсан байна.</li> </ul>         | <ul style="list-style-type: none"> <li>- Мэдээллийн ил тод байдал, мэдээлэл авах эрхийн тухай хуулийн дараах заалттай нийцүүлэх: 7.1.5 шинээр боловсруулж байгаа бодлогын баримт бичиг болон захиргааны хэм хэмжээний актын шийдвэрийн төслийг цахим хуудсандаа 30-аас доошгүй хоног ойлгомжтой байдлаар байрлуулж, холбогдох төрийн ба төрийн бус байгууллага, мэргэжлийн шинжээч, эрдэмтэн, иргэдийн саналыг авах, үндэслэлтэй гэж үзвэл уг саналыг төсөлд тусгах;</li> <li>- Захиргааны ерөнхий хуульд заасан захиргааны акт батлан гаргахын өмнө эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж болзошгүй этгээдээс тайлбар, санал авах зорилготой сонсох ажиллагааг зохион байгуулах зохицуулалттай уялдуулах</li> </ul> |

### 3.3 Хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний явцад олон нийтийн оролцоог хангах тухай

Журамд хуримтлагдах үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах тухай дараах заалтууд байна. Үүнд:

2.2.Хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний явцад олон нийтийн оролцоог дараах байдлаар хангана:

2.2.1.хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ хийхээр сонгогдсон баг нь хуримтлагдах нөлөөллийн үнэлгээнд тухайн орон нутгийн иргэд, байгууллагаас санал авч, нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулах хэлэлцэх;

2.2.2.хэлэлцүүлэгийн хүрээнд тухайн бүс нутаг, нутаг дэвсгэрийн хэмжээнд байгаль орчны суурь төлөв байдал түүний өөрчлөлтийг авч үзэх;

2.2.3.хуримтлагдах нөлөөллөөс байгаль орчин, нийгэм, хүний эрүүл мэндэд үзүүлсэн болон үзүүлж буй гол сөрөг нөлөөлөл, түүний үр дагаврын тухай; төслүүдийн хуримтлагдсан нөлөөллийн эрчим, цар хүрээ (цаг хугацаа, орон зай), тархалтыг тогтоох;

2.2.4.нөлөөллийг бууруулахад чиглэсэн арга хэмжээний талаарх санал, зөвлөмжийг тусгах.

2.3.Нээлттэй хэлэлцүүлгийн үр дүнг хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний тайланд тусгана.

БОНБУ-ний хуулийн 3.1.5-д зааснаар “хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ” гэж тодорхой бүс нутаг, сав газарт иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас хэрэгжүүлж байгаа төслүүдээс хүн амын эрүүл мэндэд үзүүлж байгаа хам болон давхардмал сөрөг нөлөөллийг тодорхойлж, түүнийг бууруулах, арилгах арга хэмжээ тогтоохыг хэлнэ. Одоогийн байдлаар Дэлхийн банкны “Уул уурхайн дэд бүтцийн

хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл"-ийн санхүүжилтээр Грийнртендс ХХК Тавантолгой ба Багануурын нүүрсний уурхайн бүс нутгийн хуримтлагдах нөлөөллийн үнэлгээг тус бүр хийсэн байна. Үнэлгээг хийхдээ Дэлхийн Банкны Олон нийтийн хэлэлцүүлэг, мэдээллийн нээлттэй байдлын журам болон Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах тухай журмыг баримталсан байна.

Дараах хүснэгтэд журмын зохицуулалтыг үндсэн шалгуурын дагуу үнэлж, анхаарах асуудлуудыг тодорхойлов.

| Шалгуур                       | Тайлбар  | Санал   |
|-------------------------------|--|---|
| Ойлгомжгүй байгаа хэсэг       | <ul style="list-style-type: none"> <li>- 2.2.1-ийн “санал авч, нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулах хэлэлцэх” гэсэн заалт утга найруулга, нэр томъёо ойлгомжгүй байна.</li> <li>- 2.2.1-д “тухайн орон нутгийн иргэд, байгууллагаас санал авах”, “нээлттэй хэлэлцүүлэг” гэсэн салаа утгатай томъёолол орсон байна.</li> </ul>   | <ul style="list-style-type: none"> <li>- Нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулах замаар санал авах, нээлттэй хэлэлцүүлгээс өөр арга хэлбэрээр санал авах гэсэн ялгааг тодорхой тусгах</li> <li>- Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын 2012 оны 6 дугаар сарын 13-ны өдрийн 183 дугаар тушаалаар батлагдсан “Хот тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төслийг олон нийтээр хэлэлцүүлэх журам”-д заасанчлан олон нийтийн хэлэлцүүлэг нь хэлэлцүүлэг зохион байгуулах тухай шийдвэр гаргах, хэлэлцүүлгийн бэлтгэл хангах, хэлэлцүүлгийг олон нийтэд зарлах, хэлэлцүүлэгт санал ирүүлэх, хэлэлцүүлэг зохион байгуулах, саналыг төсөлд тусгах, саналыг төсөлд тусгасан талаар мэдээлэх, хэлэлцүүлгийн үр дүнг эрх бүхий байгууллагад танилцуулах гэсэн дарааллаар явагдах нарийвчилсан зохицуулалтыг тусгах.</li> </ul> |
| Уялдаа холбоог анхаарах хэсэг | <ul style="list-style-type: none"> <li>- 2.2.2-т “нөлөөллийг бууруулахад чиглэсэн арга хэмжээний талаарх санал, зөвлөмжийг тусгах” тусгайлан заасан нь хуульд заасан шууд ба дам нөлөөллийг зөв тогтоох зорилгыг орхигдуулсан зохицуулалт болсон байна.</li> <li>- 2.3 дахь заалтад “Нээлттэй хэлэлцүүлгийн үр дүнг хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний тайланд тусгана” гэсэн нь хэт ерөнхий байна.</li> <li>- Олон нийтийн нээлттэй хэлэлцүүлгийг зохион байгуулж санал авах, бусад аргаар санал авах тохиолдолд олон нийтэд мэдээлэх хугацаа, арга хэлбэр, давтамжийг зохицуулалгүй орхигдуулсан байна.</li> </ul> | <ul style="list-style-type: none"> <li>- Хууль тогтоомжийн тухай хуулийн 38.6-р заалтад зохицуулсан жишгээр “олон нийтийн хэлэлцүүлгийн хугацаа дууссан өдрөөс хойш 30 хоногийн дотор төсөлд тусгасан болон тусгаагүй саналын товъёгийг бэлтгэн албан ёсны цахим хуудсандаа байршуулна” гэж оруулах.</li> <li>- “Хот тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төслийг олон нийтээр хэлэлцүүлэх журам”-д заасан жишгээр хэлэлцүүлэг болох он, сар, өдөр, байр, цаг, үргэлжлэх хугацаа, иргэдийн санал хүлээн авах харилцаа холбооны болон электрон шуудангийн хаяг, лавлагаа авах, хэлэлцүүлэгт биечлэн оролцохоор бүртгүүлэх утасны дугаар, хаягийг дурдсан албан ёсны зарыг ажлын хэсэг хэлэлцүүлэг зохион байгуулахаас 30 хоногийн өмнө өдөр тутмын болон орон нутгийн хэвлэл, интернэт, хөдөлгөөнт холбооны</li> </ul>     |

|  |  |   |
|--|--|---|
|  |  | <p>сүлжээ болон бусад мэдээллийн хэрэгслэлээр зарлахаас гадна зарыг Засаг даргын Тамгын газар болон банк, худалдаа үйлчилгээний төв зэрэг олон нийтийн газруудад байрлуулна.</p> <p>- Тайлангийн төсөл, техникийн бус хураангуйг цахим хуудсандаа 30-аас доошгүй хоног ойлгомжтой байдлаар байрлуулах, санал хүлээн авах харилцаа холбооны болон электрон шуудангийн хаяг, хариуцсан хүний хаягийг мэдээлэх</p> |
|--|--|---|

### 3.4 Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээний явцад олон нийтийн оролцоог хангах

БОНБУ-ний хуульд зааснаар байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээг байгалийн нөөцийг ашиглах, газрын тос болон ашигт малтмал хайх, ашиглах, аж ахуйн зориулалтаар газар эзэмших, ашиглах эрх авах болон төсөл хэрэгжүүлэхээс өмнө хийнэ. Төсөл хэрэгжүүлэгч нь холбогдох эрх бүхий байгууллагаар баталгаажсан техник-эдийн засгийн үндэслэл, зураг төсөл, төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчны өнөөгийн төлөв байдлын тодорхойлолт, тухайн сум, дүүргийн Засаг даргын санал болон холбогдох бусад баримт бичгийг бүрдүүлэн энэ хуульд заасан ангиллын дагуу байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, эсхүл байгаль орчны албанд байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийлгэдэг.

Журамд ерөнхий үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах тухай дараах 2 заалт байна. Үүнд:

- 2.4. Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээний явцад олон нийтийн оролцоог дараах байдлаар хангана:
- 2.4.1. орон нутгийн захиргааны байгууллага нь тухайн орон нутагт хэрэгжих төслийн талаарх мэдээллийг олон нийтэд нээлттэй байлгах;
- 2.4.2. байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон орон нутгийн байгууллага нь байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээний шийдвэр, тухайн төсөлд иргэд, олон нийтээс өгсөн саналыг байгаль орчны мэдээллийн санд оруулах.

Дараах хүснэгтэд журмын зохицуулалтыг үндсэн шалгуурын дагуу үнэлж, анхаарах асуудлуудыг тодорхойлов.

| Шалгуур                 | Тайлбар   | Санал  |
|-------------------------|---|--|
| Ойлгомжгүй байгаа хэсэг | - 2.4.1-д “орон нутгийн захиргааны байгууллага”, “төслийн талаарх мэдээлэл”, “олон нийтэд нээлттэй байлгах” гэж заасан нь нэг мөр ойлгомжгүй байна. | - “Аймаг, нийслэлийн байгаль орчны алба нь ерөнхий үнэлгээ хийх төслийн хураангуй мэдээлэл цахим хуудсандаа 10-аас доошгүй хоног ойлгомжтой байдлаар байрлуулах, санал хүлээн авах харилцаа холбооны болон электрон шуудангийн хаяг, хариуцсан хүний хаягийг мэдээлэх” гэж тодорхой тусгах |

|                               |  |   |
|-------------------------------|--|---|
| Уялдаа холбоог анхаарах хэсэг | <ul style="list-style-type: none"> <li>- 2.4.2-д “тухайн төсөлд иргэд, олон нийтээс өгсөн саналыг байгаль орчны мэдээллийн санд оруулах” гэж заасан боловч саналыг хэзээ, ямар арга хэлбэрээр, хэн хүлээн авах талаар зохицуулаагүй орхигдуулсан байна.</li> <li>- 2.4.2-д “мэдээллийн санд оруулах” гэсэн боловч хэзээ гэдэг нь тодорхой бус орхигдуулсан байна.</li> </ul> | <ul style="list-style-type: none"> <li>- “Ерөнхий үнэлгээний дүгнэлт гарснаас хойш 7 хоногийн дотор дүгнэлтэд тусгасан болон тусгаагүй саналын товъёгийг бэлтгэн албан ёсны цахим хуудсандаа байршуулах, 14 хоногийн дотор байгаль орчны мэдээллийн санд оруулах” гэж тусгах</li> </ul> |
|-------------------------------|--|---|

### 3.5 Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний явцад олон нийтийн оролцоог хангах

Журамд нарийвчилсан үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах тухай дараах заалтууд байна. Үүнд:

2.5. Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний явцад олон нийтийн оролцоог дараах байдлаар хангана:

2.5.1. үнэлгээ хийх эрх бүхий аж ахуйн нэгж нь байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний үе шатанд олон нийтийн оролцоог хангана.

2.5.2. үнэлгээ хийх эрх бүхий аж ахуйн нэгж нь байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний судалгаагаар нөлөөллийг тогтоох, таамаглах, үнэлэх үе шатан дахь олон нийтийн оролцоог хангахдаа дараах асуудлыг тусгана.

2.5.3. нөлөөллийг таамаглах үе шатанд иргэдтэй уулзалт хийх, оролцооны аргаар үнэлэх аргачлалыг ашиглан иргэдийн саналыг бүрэн авах;

2.5.4. нөлөөллийн үнэлгээний үе шатанд олон нийтийн оролцоог зөвлөлгөөн, хэлэлцүүлэг, санал асуулга явуулах замаар төслийн шууд болон шууд бус нөлөөллийг үнэлж, иргэдийн амьжиргаа, нийгмийн асуудлыг тусгахад анхаарах.

2.6. Төсөл хэрэгжүүлэгч төслийн талаарх ойлголт, эерэг, сөрөг нөлөөлөл, түүнийг бууруулах арга хэмжээний талаар нөлөөлөлд өртөж болзошгүй иргэдэд дэлгэрэнгүй танилцуулж, иргэд, олон нийтийн оролцоог хангахад шаардагдах баримт бичгийг бүрдүүлж өгч болно.

2.7. Үнэлгээний эрх бүхий аж ахуйн нэгж нь төсөл хэрэгжүүлэгчтэй хамтран байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан болон байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулж дууссаны дараа үнэлгээний тайлан, олон нийтийн саналын нэгдсэн дүнг ажлын 15 өдрийн хугацаанд тухайн нутаг дэвсгэрийн баг, хорооны нийтийн хурлаар хэлэлцүүлж санал авна.

2.8. Хэрэв тухайн төсөл нь хэд хэдэн баг, сумын нутаг дэвсгэрийг хамарч хэрэгжих бол тухайн сумын иргэдийн төлөөлөгчдийн хурал, багийн иргэдийн нийтийн хуралд тус тусад нь танилцуулж санал авна.

2.9. Үнэлгээний эрх бүхий аж ахуйн нэгж нь байгаль орчны менежментийн төлөвлөгөө, түүний хэрэгжилтийн шалгуур үзүүлэлтийг боловсруулах явцад олон нийтийн оролцоог хангах арга хэмжээг төслийн нөлөөлөлд өртөж болзошгүй иргэдийн саналын дагуу тусгаж, тэдний оролцоог хэрхэн хангах арга замыг тодорхой болгосон байна.

2.10. Нөлөөлөлд өртөж болзошгүй иргэд нь байгаль орчны нөлөөллийн үнэлгээтэй холбогдсон саналаа тухайн баг, хорооны Иргэдийн нийтийн хуралд төслийн талаар эцсийн шийдвэр гаргахаас өмнө хүргүүлсэн байна.

2.11. Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний батлагдсан тайланг олон нийтэд нээлттэй байлгах үүргийг төсөл хэрэгжүүлэгч, сум дүүргийн Засаг дарга, баг, хорооны Иргэдийн нийтийн хурал болон аймаг нийслэлийн байгаль орчны газар хариуцна.

2.12. Төсөл хэрэгжүүлэгч нь батлагдсан Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх явцад олон нийтийн оролцоог хангаж, хэрэгжилтийг жилд нэгээс доошгүй удаа тухайн төсөл хэрэгжиж буй нутгийн иргэд, олон нийтэд танилцуулж байна.

Дараах хүснэгтэд дээрх зохицуулалтыг үндсэн шалгуурын дагуу үнэлж, анхаарах асуудлуудыг тодорхойлов.

| Шалгуур                 | Тайлбар  | Санал  |
|-------------------------|--|--|
| Ойлгомжгүй байгаа хэсэг | <ul style="list-style-type: none"> <li>- 2.5 дахь заалт нь “нарийвчилсан үнэлгээний явцад олон нийтийн оролцоог дараах байдлаар хангана” буюу үнэлгээний тайлангийн төслийг боловсруулж дуусахаас өмнөх оролцоонд хамаарах зохицуулалт гэж ойлгогдохоор байгаа бол 2.5.1 дэх заалт нь “нарийвчилсан үнэлгээний үе шатанд олон нийтийн оролцоог хангана” гэсэн явцад гэдгээс өргөн хүрээтэй байна.</li> <li>- 2.5.2-т “нөлөөллийг тогтоох, таамаглах, үнэлэх үе шатанд” гэсэн нь БОНБУ-ний хууль, холбогдох журам, аргачлалд байхгүй, утгын алдаатай нэр томьёо байна.</li> <li>- 2.5.2-т “олон нийтийн оролцоог хангахдаа дараах асуудлыг тусгана” гэж заасан боловч ямар асуудал тусгахыг дэд заалтаар биш 2.5.3-2.5.4 дэх заалтаар оруулсан.</li> <li>- 2.5.3 “нөлөөллийг таамаглах үе шат” гэдэг нэр томьёо нэг мөр ойлгомжгүй байна. Энэ нэр томьёо БОНБУ-ний хууль, журам, аргачлалд огт байхгүй байна.</li> <li>- 2.5.4-д “нөлөөллийн үнэлгээний үе шатанд” гэдэг нь 2.5.2-т заасан нарийвчилсан үнэлгээний судалгааг хийх арга зүйн нэг үе шат гэж шууд ойлгогдохооргүй байна.</li> <li>- 2.5.4-ийн “олон нийтийн оролцоог” гэсэн нь заалтыг утга найруулгын алдаатай болгосон байна.</li> <li>- 2.7 дахь “олон нийтийн саналын нэгдсэн дүн” гэдэг нь нэр томьёо нэг мөр ойлгомжгүй байна.</li> <li>- 2.7-д “баг, хорооны нийтийн хурлаар” гэдэг буруу нэр томьёо орсон байна.</li> <li>- 2.9 дахь утга найруулгын хувьд ойлгомжгүй байна. Менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд иргэдийн оролцоог хэрхэн арга замыг тодорхойлсон байна гэж нэг мөр ойлгогдохгүй байна.</li> </ul> | <ul style="list-style-type: none"> <li>- 2.5 дахь заалт нь нарийвчилсан үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах, 2.5.1 нарийвчилсан үнэлгээний явцад олон нийтийг оролцоох хангах гэсэн шатлалаар томьёолох</li> <li>- 2.5.2-2.5.4 дэх заалтыг буюу нарийвчилсан үнэлгээ хийх явцын оролцоог хангах зохицуулалтыг Байгаль орчны нарийвчилсан үнэлгээ хийх аргачлалд заасан нарийвчилсан үнэлгээг хийх үе шатуудтай уялдуулах, үүнд: <ul style="list-style-type: none"> <li>- Нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний ажлын удирдамжийг олон нийтэд мэдээлэх, уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулах, бичгээр санал авах</li> <li>- Төслийн болзошгүй болон гол сөрөг нөлөөллийг тодорхойлж, сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, үр дагаврыг арилгах арга хэмжээг тодорхойлох, нөхөн сэргээх болон дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг тогтоосны дараа орон нутгийн иргэдэд танилцуулга хийж, санал авах</li> <li>- Хэлэлцүүлэг зохион байгуулж санал авахдаа хөгжлийн бэрхшээлтэй иргэд оролцоход шаардлагатай арга, хэлбэрийг сонгох, дэмжлэг үзүүлэх</li> </ul> </li> <li>- 2.7 дахь заалтын “олон нийтийн саналын нэгдсэн дүн” гэдгийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 38.6-р заалтад зохицуулсан жишгээр “төсөлд тусгасан болон тусгаагүй саналын товъёг” гэж өөрчлөх</li> </ul> |

|                                      |   |  |
|--------------------------------------|---|--|
|                                      | <ul style="list-style-type: none"> <li>- 2.10-д “төслийн талаар эцсийн шийдвэр гаргахаас өмнө” гэж заасан нь нарийвчилсан үнэлгээний талаарх БОАЖЯ-ны шийдвэр үү, баг, хорооны ИНХ-аар төслийн тайланг хэлэлцсэн тухай тогтоол уу гэдэг нь нэг мөр ойлгомжгүй байна.</li> </ul>   |  |
| <p>Уялдаа холбоог анхаарах хэсэг</p> | <ul style="list-style-type: none"> <li>- 2.7-д “ажлын 15 өдрийн хугацаанд тухайн нутаг дэвсгэрийн баг, хорооны нийтийн хурлаар хэлэлцүүлж санал авна” гэсэн үүргийг үнэлгээ эрхлэгчид хүлээлгэсэн нь Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн тухай хууль дахь баг, хорооны Иргэдийн нийтийн хурлын хуралдааны давтамж, ирцийн шалгуур, хурлаар хэлэлцсэн асуудлаар тогтоол гаргах дэгийн тухай зохицуулалттай уялдаагүй байна.</li> <li>- 2.7-д “баг, хорооны нийтийн хурлаар хэлэлцүүлж санал авна” гэж заасан нь БОНБУ-ний тухай хуулийн 8.4.8 буюу “төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн захиргаа, төслийн нөлөөлөлд өртөх нутгийн иргэдийн нийтийн хурлын санал, тэмдэглэл” гэдэг заалтыг нарийвчлан зохицуулалгүй орхигдуулсан байна.</li> <li>- 2.8-д “тухайн сумын иргэдийн төлөөлөгчдийн хурал”-ын санал гэсэн нь БОНБУ-ний тухай хуулийн 8.4.8 буюу “төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн захиргаа, төслийн нөлөөлөлд өртөх нутгийн иргэдийн нийтийн хурлын санал, тэмдэглэл” гэдэг заалттай нийцэхгүй байна.</li> <li>- 2.11-д батлагдсан тайланг нээлттэй байлгах үүргийг төсөл хэрэгжүүлэгч, сум дүүргийн Засаг дарга, баг, хорооны Иргэдийн нийтийн хурал болон аймаг нийслэлийн байгаль орчны газар хариуцуулсан нь БОНБУ-ний тухай хуулийн 8.7-д заалттай нийцэхгүй буюу хуулиар баг, хороонд тайлангийн хувийг өгөх зохицуулалтгүй байна.</li> <li>- 2.12 дахь нь утга агуулгын хувьд журмын 2.5.2-2.5.5 дахь заалттай давхардсан агуулгатай байна.</li> </ul> | <ul style="list-style-type: none"> <li>- 2022 оны 1 сараас мөрдөгдөх Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн тухай шинэ хуульд ИНХ улирал бүр наад зах нь нэг удаа хуралдахаар зохицуулсантай уялдуулж, 2.7 дахь заалтад үнэлгээ эрхлэгч нь баг, хорооны ИНХ-ын ээлжит хуралдаанаар үнэлгээний тайлан, менежментийн төлөвлөгөөг хэлэлцүүлэх хүсэлтээ хуралдаан болохоос 15-аас доошгүй хоногийн өмнө хүргүүлнэ гэж өөрчлөлт оруулах замаар олон нийтэд мэдээлэл хүргэх хугацаагаар хангах</li> <li>- Үнэлгээ эрхлэгч, төсөл хэрэгжүүлэгч нь ИНХ-аар хэлэлцүүлэх он, сар, өдөр, байр, тайлан, менежментийн төлөвлөгөөтэй танилцах цахим хуудас, иргэдийн санал хүлээн авах харилцаа холбооны болон электрон шуудангийн хаяг, лавлагаа авах утасны дугаар, хаягийг дурдсан албан ёсны зарыг ИНХ-ын хуралдаан болохоос 10-аас доошгүй хоногийн өмнө өдөр тутмын болон орон нутгийн хэвлэл, интернэт, хөдөлгөөнт холбооны сүлжээ болон бусад мэдээллийн хэрэгслээр зарлахаас гадна зарыг Засаг даргын Тамгын газар болон банк, худалдаа үйлчилгээний төв зэрэг олон нийтийн газруудад байрлуулна.</li> <li>- Үнэлгээ эрхлэгч нь тайлан, тайлангийн техникийн бус хураангуй, менежментийн төлөвлөгөөг ИНХ-аар хэлэлцүүлэхээс 10-аас доошгүй хоногийн өмнө цахим хуудсанд ойлгомжтой байдлаар байршуулна.</li> <li>- Үнэлгээ эрхлэгч нь тайлангийн техникийн бус хураангуйг хэвлэмэл хэлбэрээр баг, хорооны удирдлагад хангалттай тоогоор хүргүүлнэ. Үнэлгээ эрхлэгч, төсөл хэрэгжүүлэгч орон нутгийн удирдлагатай хамтран тайлангийн хураангуй мэдээллийг иргэдэд урьдчилж тарааж болно.</li> <li>- Үнэлгээ эрхлэгч нь тайлан, менежментийн төлөвлөгөөний танилцуулгыг энгийн хүмүүст ойлгомжтой, техникийн бус үг хэллэгээр хийнэ.</li> </ul> |

|  |  |   |
|--|--|---|
|  | <ul style="list-style-type: none"> <li>- 2.12-т “иргэд, олон нийтэд танилцуулж байна” гэж заасан ч ямар арга, хэлбэрээр гэдгийг зохицуулалгүй орхигдуулсан. Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журмын 7-р зүйл буюу байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах, түүнийг хянаж хүлээн авах зохицуулалттай уялдаагүй байна.</li> <li>- ИНХ-аар хэлэлцүүлэх хүсэлт гаргах, хэлэлцүүлэх талаар зар мэдээлэл хүргэх, тайлан, менежментийн төлөвлөгөөг олон нийтэд мэдээлэх талаар зохицуулалгүй орхигдуулсан байна.</li> <li>- ИНХ-аар тайлан, менежментийн төлөвлөгөөг хэлэлцүүлэх үйл ажиллагааны дэг, үүнд хэлэлцүүлэгт зориулсан техникийн бус хураангуйг хэвлэмэл хэлбэр урьдчилж тараах, хэлэлцүүлэгт үнэлгээ эрхлэгчийн хийх танилцуулгын агуулгын хүрээ, хуралдааны явцад бичгээр болон амаар санал авах арга хэлбэр, хуралдааны тэмдэглэл хөтлөх, саналын товъёг боловсруулах зэргийг тусгаагүй орхигдуулсан байна.</li> </ul> | <ul style="list-style-type: none"> <li>- Хэлэлцүүлгийн явцад бичгээр асуулт, санал өгөх боломжтой байх ба саналын маягтын жишиг загварыг төрийн эрх бүхий байгууллага батална.</li> <li>- Хуралдааны тэмдэглэл хөтлөх, саналын товъёг боловсруулах, ИНХ-ын тогтоол боловсруулах жишиг загварыг төрийн эрх бүхий байгууллага батална.</li> </ul> |
|--|--|---|

### 3.6 Үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах ажлын санхүүжилт

Журамд олон нийтийн оролцоог хангах ажлын санхүүжилтийн тухай дараах 3 заалт байна. Үүнд:

3.1. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд олон нийтийн оролцоог хангахтай холбоотой арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай зардлыг бодлого, хөтөлбөр санаачлагч, төсөл хэрэгжүүлэгч хариуцна.

3.2. Төсөл хэрэгжүүлэгч нь үнэлгээний эрх бүхий мэргэжлийн байгууллагатай хийсэн гэрээнд орон нутгийн иргэд, олон нийтийн оролцоог хангах үйл ажиллагаатай холбогдох зардлын асуудлыг тусгасан байна.

3.3. Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрт төсөл хэрэгжүүлэгчээс төслийг танилцуулах хурал, мэргэжлийн байгууллагаас төслийн байгаль орчны нөлөөлөх байдлын үнэлгээний талаар танилцуулах хурлын ирцийг бүрдүүлэх нэмэлт зардлыг төсөл хэрэгжүүлэгч, орон нутгийн удирдлага хамтран хариуцаж болно.

Дараах хүснэгтэд журмын зохицуулалтыг үндсэн шалгуурын дагуу үнэлж, анхаарах асуудлуудыг тодорхойлов.

| Шалгуур | Тайлбар | Санал |
|---------|---------|-------|
|---------|---------|-------|

|                               |  |   |
|-------------------------------|--|---|
| Ойлгомжгүй байгаа хэсэг       | <ul style="list-style-type: none"> <li>- 3.3-т заасан “төслийг танилцуулах хурал”, “үнэлгээний талаар танилцуулах хурал” гэдэг нэр томъёо журмын өмнөх зүйл, заалтуудад тусгагдаагүй байна.</li> <li>- 3.3-т заасан ирц бүрдүүлэх нэмэлт зардал нь тодорхой шалтгааны улмаас хуралд оролцоход бэрхшээлтэй байгаа иргэдийг оролцуулахад зориулсан зардал гэж нэг мөр ойлгогдохгүй байна.</li> </ul> | <ul style="list-style-type: none"> <li>- 3.2-ын “орон нутгийн иргэд, олон нийтийн оролцоог хангах үйл ажиллагаатай холбогдох зардлын асуудлыг” гэснийг олон нийтийн оролцоог хангах үйл ажиллагааны зардлыг гэж тодорхой заах.</li> </ul> |
| Уялдаа холбоог анхаарах хэсэг |  | <ul style="list-style-type: none"> <li>- 3.3 хөгжлийн бэрхшээлтэй иргэн, алслагдмал байршилд амьдарч буй өрхийг оролцоог хангахад шаардлагатай нэмэлт зардлыг гэж нэмж тусгах</li> </ul>  |

### 3.7 Гомдол маргаан шийдвэрлэх

Журамд ерөнхий үнэлгээнд гомдол маргаан шийдвэрлэх тухай дараах заалтууд байна. Үүнд:

4.5.Байгаль орчны стратегийн болон нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлангийн талаарх гомдол, маргааныг иргэд, олон нийтийн зүгээс төсөл хэрэгжүүлэгч, тухайн төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг хийсэн эрх бүхий аж ахуйн нэгж, орон нутгийн удирдах байгууллагад эхлэн гаргана.

3.6.Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний тайланд тусгагдаагүй, эсвэл дутуу орсон, буруу хийсэн зэргээс үүдэлтэй гомдол маргааныг иргэд, олон нийтийн зүгээс төсөл, орон нутгийн удирдах байгууллага болон байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад шат дараалан тавина.

3.7.Шат дараалан тавьсан гомдол, маргааны шийдвэрийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага холбогдох хууль тогтоомжийн хүрээнд гаргах бөгөөд хянан шийдвэрлэсэн дүгнэлтийг иргэд, олон нийт хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд шүүхээр шийдвэрлүүлэх эрхтэй.

Дараах хүснэгтэд дээрх заалтуудыг үндсэн шалгуурын дагуу үнэлж, анхаарах асуудлуудыг тодорхойлов.

| Шалгуур                 | Тайлбар   | Санал  |
|-------------------------|---|--|
| Ойлгомжгүй байгаа хэсэг | <ul style="list-style-type: none"> <li>- 4.5-д “гомдол гаргах, түүнийг шийдвэрлэх”, “маргааныг зохицуулах, шийдвэрлэх” гэдэг ойлголтуудыг ялгаж тусгаагүй байна.</li> <li>- 3.6 дахь заалт дугаарлалт болон найруулгын алдаатай байна.</li> <li>- 3.6-д “үнэлгээний тайланд тусгагдаагүй, эсвэл дутуу орсон, буруу хийсэн зэргээс үүдэлтэй гомдол маргааныг” гэж тусгайлан заасан нь ямар үндэслэлтэй болох нь ойлгомжгүй. Үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах үүргийн хэрэгжилттэй холбоотой</li> </ul> | <ul style="list-style-type: none"> <li>- “Өргөдөл, гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх”, “маргааныг зохицуулах, шийдвэрлэх” тус бүрд нь тодорхой тусгах</li> <li>- Хууль, журмаар заасан оролцоог хангах үүргийн хэрэгжилттэй холбоотой аливаа асуудлаар гомдол гаргах эрхийг тодорхой тусгах</li> <li>- Төсөл хэрэгжүүлэгч, үнэлгээ эрхлэгчийн иргэдийн гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх, хариу өгөх үүргийг тусгах</li> </ul> |



|                               |  |   |
|-------------------------------|--|---|
|                               | гомдол энэ заасан хүрээнд орох эсэх нь ойлгомжгүй байна.   |   |
| Уялдаа холбоог анхаарах хэсэг | <ul style="list-style-type: none"> <li>- Шат дараалан гомдол гаргасны эцэст шийдэгдээгүй бол БОАЖЯ хүлээн авч шийдвэрлэнэ гэсэн босго, шаардлага тавьсан нь хүний эрхийг хязгаарласан шинжтэй байна.</li> <li>- Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн гомдол хүлээн авах, хянан үзэх, шийдвэрлэх, хариу өгөх, шийдвэрийн хэрэгжилтийг хангах зохицуулалттай уялдаагүй, хэт ерөнхий зохицуулсан байна.</li> <li>- Маргаантай харилцааг зохицуулах талаар орхигдуулсан байна.</li> </ul> | <ul style="list-style-type: none"> <li>- Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай хуульд нийцүүлэн орон нутгийн удирдлага, БОАЖЯ-ны үүргийг тодорхой тусгах</li> <li>- Захиргааны ерөнхий хуулийн дагуу байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг хийх явцын хэлэлцүүлэг болон ИНХ-аар тайланг хэлэлцүүлэх үйл ажиллагаатай холбоотой оролцогч талуудын хооронд үүссэн маргааныг шийдвэрлэх талаар иргэн хүсэлт гаргасан, эсхүл захиргааны байгууллага шаардлагатай гэж үзвэл БОАЖЯ-наас шинжээч томилон дүгнэлт гаргуулах зохицуулалт оруулах</li> </ul> |

#### 4. Журмын хэрэгжилтийн үнэлгээ

Энэ төслийн хүрээнд БОНБУ-нд оролцогч талуудын судалгаа хийсний зэрэгцээ батлагдсан нарийвчилсан үнэлгээний тайлангийн олон нийтийн оролцоог хангасан баримт бичиг болох ИНХ-ын тогтоол, тэмдэглэлд дүн шинжилгээ хийж журмын хэрэгжилтийг үнэлэхийг зорьсон.

*Нарийвчилсан үнэлгээний явцад олон нийтийн оролцоог хангах зохицуулалтын хэрэгжилт (2.5.3, 2.5.4, 2.7, 2.10)*

Үнэлгээ эрхлэгч аж ахуйн нэгжүүдийн төлөөлөл 30 мэргэжилтэнтэй ярилцахад зөвхөн 20 хувь нь нарийвчилсан үнэлгээ хийх явцад орон нутгийн иргэдээс санал авдаг гэж хариулсан. Харин баг, хороо, сум, дүүргийн удирдлагын төлөөлөл 30 оролцогчоос 6 нь үнэлгээ эрхлэгчид айлуудаар явж судалгаа авах, ганцаарчилж уулзах ажил хийдэг талаар дурдсан байна. Харин төсөл хэрэгжүүлэгч 40 компанийн төлөөлөл үнэлгээг хийх явцад үнэлгээ эрхлэгчид иргэдээс санал авдаг талаар тодорхой мэдээлэлгүй байна.

Нарийвчилсан үнэлгээний 22 тайлангийн ИНХ-ын хэлэлцүүлгийн тэмдэглэл, тогтоолд дүн шинжилгээ хийхэд журамд заасан үнэлгээ хийх явцад иргэдэд шаардлагатай мэдээлэл өгсөн, танилцуулга хийсэн, санал авч, хэлэлцүүлэг зохион байгуулсан эсэх талаар огт дурдаагүй байна. Харин иргэд төслийн болон БОННУ-ний талаар урьдчилсан мэдээлэл авалгүйгээр хуралд оролцсон болохыг илтгэж буй асуулт, саналууд байна. Үүнд:

- Төслийн үйл ажиллагааны тухай ерөнхий мэдээлэл асуух
- Төслийн байгаль орчны нөлөөллийн талаар ерөнхий асуулт асуух
- Үнэлгээний тайлангийн төслийг хаанаас уншиж болох тухай асуух

Түүнчлэн, журмын 2.7-д заасан нарийвчилсан үнэлгээний тайланг ИНХ-аар хэлэлцүүлэхдээ хамтад танилцуулж хэлэлцүүлэх ёстой олон нийтийн саналын нэгдсэн дүнгийн талаар нэг ч хурлын тэмдэглэлд дурдаагүй байна.

Үүнээс үзэхэд нарийвчилсан үнэлгээний явцад олон нийтийг оролцоог хангах журмын зохицуулалтын хэрэгжилт маш хангалтгүй байна.

*Нарийвчилсан үнэлгээний тайланг ИНХ-аар хэлэлцүүлж, санал авах зохицуулалтын хэрэгжилт (2.7, 2.8)*

Журмын 2.7-д заасан баримт бичгүүдийг ажлын 15 өдрийн хугацаанд баг, хорооны ИНХ-аар хэлэлцүүлж санал авах зохицуулалт ч амьдралд нийцэлгүй байгааг судалгаа харуулж байна. Баг, хороодын хурлын тогтсон хуваарь байхгүй, жилд дунджаар 2-4 удаа болдог. Зөвхөн үнэлгээний тайланг хэлэлцэх ээлжит бус хурал зохион байгуулах тохиолдол маш цөөн учраас ихэнхдээ ИНХ-ын ээлжит хуралдаанаар хэлэлцэх асуудлын жагсаалтад оруулах байдлаар үнэлгээний тайланг хэлэлцүүлж байна. Тийм учраас ИНХ болсон дээр амжиж хэлэлцүүлэх сонирхол хүчтэй байдаг нь ажиглагдаж байна. Үүнийг үнэлгээний тайлангийн дүн шинжилгээ давхар нотолж байна.

Дүн шинжилгээ хийсэн 10 тайлан буюу нийт 22 тайлангийн 45 хувь нь Ерөнхий үнэлгээний дүгнэлт батлагдсанаас хойш 1 сарын дотор ИНХ-аар хэлэлцүүлсэн байна. 5 тайланг 2-3 сарын дотор, 4 тайланг 4 сар болон түүнээс дээш хугацаанд ИНХ-аар хэлэлцүүлсэн байна. Харин 3 тайланг Ерөнхий үнэлгээ дүгнэлт гарахаас өмнө буюу БОННУ хийж эхлэхээс өмнө хэлэлцүүлсэн байна.

БОНБУ-д хуульд зааснаар ИНХ-аар нарийвчилсан үнэлгээний тайлан танилцуулж санал авдаг гэж судалгаанд оролцсон 30 үнэлгээ эрхлэгчдийн 29 нь хариулсан. Харин Улаанбаатар хотод хорооны ИНХ-ын тэргүүлэгчдийн хурал эсвэл Засаг даргын зохион байгуулсан хуралд танилцуулж санал авах байдал нийтлэг байна. Дүн шинжилгээ хийсэн 22 тайлангийн 14 нь ИНХ-ын тогтоол, хурлын тэмдэглэл, 7 нь ИНХ-ын тэргүүлэгчдийн хурлын тогтоол, хурлын тэмдэглэл, 1 нь ИТХ-ын тогтоол, тэмдэглэлийг хавсаргасан байсан. ИНХ-ын Тэргүүлэгчдийн тогтоол хавсаргасан 5 тайлан Улаанбаатар хотод, 2 нь орон нутагт байршилтай байсан. Журмын 2.8-д заасны дагуу хэд хэдэн багийн нутаг дэвсгэрийг хамарч хэрэгжих нэг төслийн хувьд ИНХ, ИТХ-ын тогтоол, хуралдааны тэмдэглэл хавсаргасан байсан.

*Нарийвчилсан үнэлгээний мэдээллийн нээлттэй, ил тод байдлыг хангах (1.3, 1.5, 2.11, 2.12)*

БОАЖЯ батлагдсан нарийвчилсан үнэлгээний талаарх мэдээллийг БОНБУ-ний мэдээллийн сангаар дамжуулан олон нийтэд мэдээлдэг. Үүнд төсөл, БОННУ-ний талаарх товч мэдээлэл, БОННУ-ний тайлангийн дараах хэсгүүдийг файлаар байршуулсан байна.

- Сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ
- Эрсдэлийн үнэлгээ, менежмент
- Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө

- Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр
- Олон нийтийн оролцоог хангуулсан талаарх баримт бичиг (2021 оны 4 сараас эхлэн)

Судалгаагаар орон нутгийн удирдлага үнэлгээний тайлангийн нэг хувийг хүлээн авдаг боловч иргэд уншиж танилцах боломж маш хязгаарлагдмал байна. Үүнд хэд хэдэн шалтгаан байгааг судалгаанд оролцогчид дурдсан байна. Үүнд:

- Үнэлгээний тайлан нь нийтэд ил тод баримт бичиг үү эсвэл нууцын зэрэглэлтэй баримт бичиг үү гэдэг ойлголт янз бүр байна.
- Үнэлгээний тайланг хаанаас үзэж танилцаж болох тухай нээлттэй мэдээлэл иргэдэд байхгүй байна.
- Орон нутгийн иргэд уншиж танилцах сонирхол бага, уншиж танилцсан ч ойлгоход бэрхшээлтэй нүсэр материал гэж үздэг учраас иргэдэд нээлттэй байлгах сонирхол бага байдаг.

Үнэлгээний тайлан батлагдахаас өмнө иргэд уншиж танилцах боломж маш байдаг гэдгийг үнэлгээ эрхлэгчид хүлээн зөвшөөрч байна. Нэгдүгээрт, хуулийн дагуу тайлан батлагдахаас өмнө орон нутагт тайланг хүргүүлэх, нээлттэй мэдээлэх хуулийн шаардлага байхгүй. Хоёрдугаарт, иргэдийн хувьд тайланг бүрэн эхээр нь унших сонирхол бага байдаг гэж үзсэн байна. Гуравдугаарт, төсөл хэрэгжүүлэгч болон үнэлгээ эрхлэгчид үнэлгээний тайлангаа олон нийтэд дэлгэх сонирхол бага байдаг байна.

Иргэдийн хувьд үнэлгээний талаарх мэдээлэл авах боломж нь ИНХ-ын хуралдаанд оролцох явдал байна. Үүнээс өөрөөр төсөл болон үнэлгээний талаар албан ёсны мэдээлэл авах боломж маш бага гэдгийг судалгаанд оролцогчид үзсэн байна. Нэгдүгээрт, төсөл хэрэгжүүлэгч, үнэлгээ эрхлэгчид урьдчилсан танилцуулга, мэдээлэл өгөх байдал хангалтгүй байна. Хоёрдугаарт, төсөл, үнэлгээний талаарх мэдээллийг шуурхай авах нэгдсэн мэдээллийн эх сурвалж байдаггүй.

*Үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах ажлын санхүүжилт (3.1, 3.2, 3.3)*

Судалгаанд оролцсон үнэлгээ эрхлэгчдийн баримжаа тооцооллоор төслийн байршил, оролцоог хангах ажлын цар хүрээнээс хамаарч үнэлгээний ажлын төсвийн 5-10 хувийг оролцоог хангахтай холбоотой ажилд зарцуулдаг байна. Үүнд гол төлөв нөлөөллийн бүсэд ажиллах, ИНХ-д оролцоход гарах тээврийн болон томилолтын зардал багтдаг байна.

Үнэлгээ эрхлэгчид үнэлгээний ажлын төсвийг төсөл хэрэгжүүлэгчтэй тохиролцоходоо оролцоог хангахад шаардлагатай зардлыг тусад тооцож оруулах боломж бага байдаг байна. Учир нь үнэлгээ эрхлэгчид ихэнхдээ төсөл хэрэгжүүлэгчидтэй үнэлгээний ажлын үнийг тохирохдоо нийт үнийн дүн санал болгодог байна. Ялангуяа жижиг, дунд хэмжээний төслийн үнэлгээний хувьд оролцоог хангахтай холбоотой зардал гэж тусад нь тавьж өгвөл төсөл хэрэгжүүлэгч ойлгож хүлээж авахгүй гэж үздэг байна.

Харин төсөл хэрэгжүүлэгчтэй гэрээ байгуулахдаа хуульд заасан иргэдийн санал авах, хэлэлцүүлэг хийх ажилтай холбоотой гарах зардлыг төсөл хэрэгжүүлэгч

талаас гаргах, хамтран ажиллах талаар тусгахыг хичээдэг байна. Улаанбаатар хот орчмын жижиг төслүүдийн үнэлгээний хувьд төсөл хэрэгжүүлэгч нь ИНХ-ын тогтоол буюу орон нутгаас “бичгээ авах” ажлыг хариуцдаг учраас оролцооны талаар зардал гэхээр зүйл нийт төсөвт багтдаггүй гэж хариулсан байна. Үүнээс үзэхэд үнэлгээний ажлын зардлын төсөвт оролцоог хангах талаар сайтар тусгаж өгдөггүйгээс аль болох бага зардлаар, шуурхай байдлаар санал авах, хэлэлцүүлэгт орох сэдэл болдог байна.

#### *Гомдол маргаан шийдвэрлэх (3.5-3.7)*

Ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой орон нутгийн удирдлага, төсөл хэрэгжүүлэгч, үнэлгээ эрхлэгчийн талаар Авлигатай тэмцэх газар гомдол гаргасан, Мэргэжлийн зөвлөлийн дүгнэлттэй холбоотой шүүхэд нэхэмжлэл гаргасан жишээг судалгаанд оролцогчид дурдсан. Журамд заасанчлан иргэд шат шатны байгууллагад гомдол гаргадаг тухай мэдээлэл байхгүй байна.

Маргаантай харилцааг зохицуулахад хөндлөнгийн шинжээч, БОАЖЯ-ны оролцоо шаардлагатай гэдэг байр суурийг уул уурхайн төсөл хэрэгжүүлэгчдийн зарим төлөөлөл онцолсон байна. Ялангуяа орон нутгийн удирдлага ИНХ-аар тайланг хэлэлцэхээс түдгэлзэх, хурлыг хойшлуулах, орон нутгийн иргэдийн сөрөг хандлага их байх тохиолдолд талуудын байр суурийг сонсох, маргааныг шийдвэрлэх тухай зохицуулалт үгүйлэгдэж байна.

Олон нийтийн оролцоог хангасан тухай баримт бичиг буюу ИНХ-ын тогтоол, тэмдэглэлийг хуурамчаар үйлдэх зөрчил байдгийг судалгаанд оролцогчид дурдаж байсан бөгөөд эдгээр тохиолдолд үнэлгээ эрхлэгч, төсөл хэрэгжүүлэгчид хүлээлгэх хариуцлагын арга хэмжээ тодорхой бус байна.

## 5. Дүгнэлт, зөвлөмж

Журмын үндсэн хэсгийн зүйл, заалт бүрийг шинжлэн үзэхэд тэдгээрийн 90 орчим хувийг нэг мөр ойлгомжтой, холбогдох хууль, журам, аргачлалтай нийцүүлэн шинэчлэн сайжруулах шаардлагатай байна.

Журмын зарим бүрэлдэхүүн хэсгүүд, ялангуяа стратегийн нөлөөллийн үнэлгээний зохицуулалт нь тодорхой хугацаа, арга хэлбэрийг тусгасан ололттой талуудтай байгаа боловч журмыг бүхэлд нь шинэчлэн боловсруулах шаардлагатай байна. Үнэлгээний тус бүр нь бие даасан бүлэгтэй, үнэлгээ эхлэхээс батлагдах хүртэлх үе шатанд оролцоог хангах шаардлага, зохицуулалтыг тодорхой тусгасан байхаар шинэчлэн боловсруулах нь үр дүнтэй юм.

2014 онд журам батлагдсанаас хойш холбогдох хуулиудад олон нийтийн оролцоог хангахтай холбоотой чухал өөрчлөлт орж, мөн шинээр хууль, журам цөөнгүй батлагдсан учраас тэдгээрт тусгагдсан зохицуулалттай уялдуулах, сайн жишгийг журамд тусгах нь зүйтэй юм. Ялангуяа олон нийтэд зар мэдээ хүргэх, мэдээлэл өгөх, хэлэлцүүлэг зохион байгуулах, олон нийтийн саналыг

боловсруулах, тайлагнах зохицуулалтуудыг журамд амьдралд нийцэлтэй байдлаар тусгах шаардлагатай байна.

Нарийвчилсан үнэлгээг хийх явцад буюу тайланг боловсруулж ИНХ-аар хэлэлцүүлэхээс өмнөх шатанд олон нийтийн оролцоог хангах үйл ажиллагааг журамд тодорхойлсон боловч энэ талаар тайлагнах, нотлох баримтаар баримтжуулах зохицуулалт байхгүй учраас хэрэгжилт хангалтгүй байна. Явцын оролцоог хангахын тулд журамд заасан олон нийтийн саналын нэгдсэн дүнг товч тайлан хэлбэрээр ИНХ-аар тайланг хэлэлцүүлэхээс өмнө олон нийтэд цахимаар нээлттэй байршуулах зохицуулалт хийх нь үр дүнтэй гэж үзэж байна.

ИНХ-аар тайланг хэлэлцүүлэх зохицуулалт нь ИНХ-ын хуваарьт нийцсэн, иргэд, олон нийтэд тайлангийн мэдээлэлтэй танилцах зохих хугацаа олгосон, хэлэлцүүлгийн дэг нь тодорхой, тэмдэглэл, тогтоолыг хууль, журмын үзэл баримтлалд нийцүүлэн журамлаж, жишиг загвар, маягтаар хангасан байх шаардлагатай байна.

Үнэлгээний тайлан, тайлангийн хураангуйг ИНХ-аар хэлэлцэхээс өмнө цахимаар байршуулах, батлагдсан тайланг цахимаар болон хэвлэмэл байдлаар иргэдэд хүртээмжтэй номын сан, иргэдийн танхимаар дамжуулж хүргэх шаардлагатай байна.

## 6. Холбогдох эрх зүйн баримт бичиг

Монгол улсын үндсэн хууль

Байгаль орчныг хамгаалах тухай хууль

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль

Захиргааны ерөнхий хууль

Захиргааны хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль

Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль

Мэдээллийн ил тод байдал, мэдээлэл авах эрхийн тухай хууль

Хууль тогтоомжийн тухай хууль

Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журам

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах тухай журам

Нийтийн сонголт зохион байгуулах журам

Байгаль орчны стратегийн болон хуримтлагдах үнэлгээ хийх аргачлал

Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх аргачлал

Хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төслийг олон нийтээр хэлэлцүүлэх журам

## 7. Хавсралт

Байгаль орчинд нөлөөлөх  
байдлын үнэлгээнд олон  
нийтийн оролцоог хангах нь:  
Иргэдийн нийтийн хурлын  
санал, тэмдэглэлд хийсэн дүн  
шинжилгээ



## Мэдэгдэл

Энэхүү тайланг Австрали Улсын Засгийн газар, Австралийн Гадаад хэрэг, худалдааны яам санхүүжүүлсэн боловч тус тайланд тусгасан үзэл санаа нь Австрали Улсын Засгийн газар бус гагцхүү зохиогчийн үзэл бодол болно. Мөн түүнчлэн энэ тайланд тусгасан үзэл баримтлалыг Австрали Улсын Засгийн газар дэмжиж байгаа гэж ойлгож болохгүй. Тус улсын Засгийн газар энэ тайланд багтсан мэдээллийн бүрэн болон үнэн зөв эсэхийг батлахгүй. Энэхүү хэвлэлд орсон тоо баримт, мэдээ материал алдаа мадагтай, дутуу хагас байж болзошгүй бөгөөд түүнээс үүдэн гарах аливаа хохиролд Австрали Улсын Засгийн газар, хариуцлагатай албан тушаалтан, ажилтан, албан хаагч, гэрээт ажилчид ямар нэг хариуцлага хүлээхгүй болно.

Энэхүү тайлан нь ерөнхий мэдээлэл өгөх зорилготой. Аливаа шийдвэр гаргахаас өмнө тайланг уншиж, хэрэглэж буй тал мэдээллийн анхдагч эх сурвалжтай холбогдон, мэдээ баримтаа лавшруулан шалгаж, бие даасан судалгаа хийн, зөвлөгөө авах нь зүйтэй.

\* \* \* \* \*

*Адам Смит Интернэйшнл компани нь Австрали Улсын Засгийн газрын санхүүжилтээр Австрали Монголын Эрдэс баялгийн салбарын хамтын ажиллагааны хөтөлбөрийн хоёрдугаар шат (АМЕП 2)-ыг хэрэгжүүлж байна.*

\* \* \* \* \*

### **Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах нь: Иргэдийн нийтийн хурлын санал, тэмдэглэлд хийсэн дүн шинжилгээ**

Энэ судалгааны тайланг “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор 2014 онд батлагдсан БОНБУ-нд олон нийтийн оролцоог хангах тухай журмыг боловсронгуй болгох төслийн хүрээнд боловсруулав. Ингэхдээ нийт 22 баримт бичиг, тэдгээрт холбогдох өгөгдөлд дүн шинжилгээ хийсэн болно.

Дүн шинжилгээг хийж, тайланг боловсруулсан: АМЕП-2 төслийн олон нийтийн оролцооны зөвлөх Доктор Д.Бямбажав

2021 оны 6 сарын 15

## Гарчиг

|   |    |
|---|----|
| 1. Дүн шинжилгээний зорилго .....   | 27 |
| 2. Дүн шинжилгээ хийсэн баримт бичгүүд.....                               | 28 |
| 3. Өгөгдлийн шинжилгээ .....  | 29 |
| 3.1 Олон нийтийн оролцоог хангасан талаарх баримт бичиг.....              | 29 |
| 3.2 ИНХ-ын тэмдэглэлийн хэмжээ, бүтэц, агуулга .....                      | 30 |
| 3.3 ИНХ-ын Тэргүүлэгчдын хурлын тэмдэглэлийн хэмжээ, бүтэц, агуулга ..... | 32 |
| 3.4 ИНХ-аар хэлэлцүүлсэн хугацаа .....                                    | 33 |
| 4. Хууль, журмын хэрэгжилт .....  | 34 |
| 4.1 БОННУ хийх явцын оролцоо .....  | 34 |
| 4.2 ИНХ-ын саналын томъёолол.....   | 35 |
| 4.3 ИНХ-ын тогтоолын хуулийн үндэслэл .....                               | 36 |
| 4.4 Албан хэрэг хөтлөлт .....   | 37 |
| 5. Дүгнэлт, зөвлөмж .....   | 38 |

## 1. Дүн шинжилгээний зорилго

БОНБҮ-ний тухай хуульд заасны дагуу Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ (БОННҮ)-ний тайланд тусгах ёстой ИНХ-ын санал, хурлын тэмдэглэл, тэдгээрт холбогдох өгөгдөлд дүн шинжилгээ хийх замаар БОНБҮ-нд олон нийтийн оролцоог хангах талаарх холбогдох хууль, журмын хэрэгжилтийг үнэлэх зорилгоор энэ судалгааг гүйцэтгэв.

БОНБҮ-ний хуулийн 18.4-д зааснаар үнэлгээ эрхлэгч нь БОННҮ хийж, тайлан боловсруулах явцдаа төслийн нөлөөлөлд өртөх нутгийн иргэд, оршин суугчдаас албан ёсоор санал авах, түүнийхээ үндсэн дээр хэлэлцүүлэг зохион байгуулах ёстой. Иргэдийн оролцоог хангах энэхүү санал авах, хэлэлцүүлэг хийх үйл ажиллагааг нотлох баримт бичиг нь БОНБҮ-ний хуулийн 8.4.8-д заасанчлан төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн захиргаа, төслийн нөлөөлөлд өртөх нутгийн иргэдийн нийтийн хурлын санал буюу хурлын тогтоол, тэмдэглэл юм. Хуулийн энэ зохицуулалтад нийцүүлэн БОНБҮ-нд олон нийтийн оролцоог хангах журмаар БОННҮ хийж% тайлан боловсруулах явцад буюу ИНХ-аар хэлэлцүүлэхээс өмнө иргэдийн саналыг авах арга, анхаарах асуудлыг тодорхойлсон.

*БОНБҮ-нд олон нийтийн оролцоог хангах журмын холбогдох заалтууд*

2.5.3.нөлөөллийг таамаглах үе шатанд иргэдтэй уулзалт хийх, оролцооны аргаар үнэлэх аргачлалыг ашиглан иргэдийн саналыг бүрэн авах;

2.5.4.нөлөөллийн үнэлгээний үе шатанд олон нийтийн оролцоог зөвлөлгөөн, хэлэлцүүлэг, санал асуулга явуулах замаар төслийн шууд болон шууд бус нөлөөллийг үнэлж, иргэдийн амьжиргаа, нийгмийн асуудлыг тусгахад анхаарах.

2.6.Төсөл хэрэгжүүлэгч төслийн талаарх ойлголт, эерэг, сөрөг нөлөөлөл, түүнийг бууруулах арга хэмжээний талаар нөлөөлөлд өртөж болзошгүй иргэдэд дэлгэрэнгүй танилцуулж, иргэд, олон нийтийн оролцоог хангахад шаардагдах баримт бичгийг бүрдүүлж өгч болно.

2.7.Үнэлгээний эрх бүхий аж ахуйн нэгж нь төсөл хэрэгжүүлэгчтэй хамтран байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан болон байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулж дууссаны дараа үнэлгээний тайлан, олон нийтийн саналын нэгдсэн дүнг ажлын 15 өдрийн хугацаанд тухайн нутаг дэвсгэрийн баг, хорооны нийтийн хурлаар хэлэлцүүлж санал авна.

2.8.Хэрэв тухайн төсөл нь хэд хэдэн баг, сумын нутаг дэвсгэрийг хамарч хэрэгжих бол тухайн сумын иргэдийн төлөөлөгчдийн хурал, багийн иргэдийн нийтийн хуралд тус тусад нь танилцуулж санал авна.

2.10.Нөлөөлөлд өртөж болзошгүй иргэд нь байгаль орчны нөлөөллийн үнэлгээтэй холбогдсон саналаа тухайн баг, хорооны Иргэдийн нийтийн хуралд төслийн талаар эцсийн шийдвэр гаргахаас өмнө хүргүүлсэн байна.

## 2. Дүн шинжилгээ хийсэн баримт бичгүүд

Ажлын даалгаврын дагуу БОАЖЯ-наас БОННУ-ний 20 тайлангийн ИНХ-ын тогтоол, хурлын тэмдэглэлийн хуулбарыг хүлээн авсан. БОАЖЯ-ны БОНБУ-ний мэдээллийн сангаас эдгээр 20 тайланд холбогдох Ерөнхий үнэлгээний дүгнэлт, БОННУ-ний тайлангийн мэдээллийг олж үнэлгээний үйл явцын бүрэн зураглалыг хийх боломжтой эсэхийг зорьсон. Ингэхэд 12 тайлангийн холбогдох мэдээлэл бүрэн байсан бол 8 тайлангийн хувьд батлагдсан БОННУ-ний мэдээллийн санд мэдээлэл нь ороогүй байсан.

2021 оны 5 сард БОАЖЯ БОНБУ-ний мэдээллийн сангийн “Батлагдсан БОННУ-ний тайлан дэлгэрэнгүй харах хэсэг”-т “Олон нийтийн оролцоог хангуулсан талаарх баримт бичиг” гэсэн шинэ дэд хэсэг нэмж, ИНХ-ын тогтоол, хурлын тэмдэглэлийг оруулж эхэлсэн. Одоогийн байдлаар 2021, 2020 оны мэдээлэл орсны дотор 2020 онд батлагдсан БОННУ-ний 10 тайлангийн ИНХ-ын тогтоол, хурлын тэмдэглэл байна.

Бүрэн мэдээлэл бүхий дээрх нийт 22 тайлангийн 9 нь Улаанбаатар хотод байршилтай, 13 нь орон нутагт буюу 10 аймагт байршилтай төслийн үнэлгээнийх байна. Үнэлгээ хийсэн чиглэлийн хувьд 7 нь уул уурхай, 11 нь ХАА, үйлдвэрлэл /үүний 9 нь үйлдвэрийн төслүүд/, 1 нь үйлчилгээ, 3 нь дэд бүтцийн хөгжлийн төслүүд байна. Тайлангуудын 10 нь буюу 45 хувь нь 2020 онд батлагдсан бол 55 хувь нь 2015-2018 онд батлагдсан байна. 22 үнэлгээний тайлангийн 6 нь нэмэлт тодотгол, 16 нь шинэ төслийн үнэлгээ байна.

### Хүснэгт 1. Дүн шинжилгээ хийсэн тайлангийн мэдээлэл

|     | Үнэлгээ хийсэн чиглэл | Төслийн нэр                                       | БОННУ батлагдсан он | Байршил    |
|-----|-----------------------|---|---------------------|------------|
| 1.  | Уул уурхай            | Алт агуулсан мөнгө-холимог металлын орд ашиглах   | 2017                | Дорнод     |
| 2.  | ХАА, үйлдвэрлэл       | Цемент, шохойн үйлдвэр                            | 2016                | Сэлэнгэ    |
| 3.  | Уул уурхай            | Харз элс хайрганы орд ашиглах                     | 2016                | УБ         |
| 4.  | Уул уурхай            | Төмөр толгойн төмрийн хүдрийн орд ашиглах         | 2018                | Дархан-Уул |
| 5.  | ХАА, үйлдвэрлэл       | Будаг боловсруулах үйлдвэр                        | 2015                | УБ         |
| 6.  | ХАА, үйлдвэрлэл       | Төмрийн хүдэр баяжуулах үйлдвэр                   | 2018                | Хэнтий     |
| 7.  | Дэд бүтцийн хөгжлийн  | Салхин парк                                       | 2016                | Говьсүмбэр |
| 8.  | ХАА, үйлдвэрлэл       | Нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэр | 2018                | Дундговь   |
| 9.  | Уул уурхай            | Газрын тосны хайгуулын ажил гүйцэтгэх             | 2017                | Дорноговь  |
| 10. | ХАА, үйлдвэрлэл       | Тэсрэх материалын агуулах                         | 2017                | УБ         |

|     |                      |  |      |           |
|-----|----------------------|--|------|-----------|
| 11. | ХАА,<br>үйлдвэрлэл   | Ноос, ноолуур боловсруулах үйлдвэр   | 2018 | УБ        |
| 12. | Уул уурхай           | Хандгайтын төмрийн хүдрийн орд   | 2015 | Сэлэнгэ   |
| 13. | ХАА,<br>үйлдвэрлэл   | Төмрийн хүдэр хуурай соронзон аргаар баяжуулах үйлдвэр   | 2020 | Хэнтий    |
| 14. | Уул уурхай           | Сайн хөөвөр хүрэн нүүрсний ордыг ашиглах   | 2020 | Сүхбаатар |
| 15. | Дэд бүтцийн хөгжлийн | Нүүрс угаах үйлдвэр  | 2020 | Өмнөговь  |
| 16. | ХАА,<br>үйлдвэрлэл   | Хаягдал төмөр боловсруулах үйлдвэр   | 2020 | Төв       |
| 17. | Уул уурхай           | Газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээт XXI талбайн гал унтраах болон ажилчдын суурингийн аюулгүй байдлыг хангах | 2020 | Дорнод    |
| 18. | ХАА,<br>үйлдвэрлэл   | Мал төхөөрөх, мах боловсруулах үйлдвэр   | 2020 | УБ        |
| 19. | Дэд бүтцийн хөгжлийн | Ашиглалтаас хасагдсан тээврийн хэрэгслийг задлан дахин боловсруулж, нөөцийг эргэлтэд оруулах төв                 | 2020 | УБ        |
| 20. | Үйлчилгээний         | Химийн бодис импортлох, хадгалах, худалдаалах  | 2020 | УБ        |
| 21. | ХАА,<br>үйлдвэрлэл   | Хуванцар хаягдал дахин боловсруулах үйлдвэр  | 2020 | УБ        |
| 22. | ХАА,<br>үйлдвэрлэл   | Адууны боловсруулсан өлөн гэдэс хатаан савлах үйлдвэр  | 2020 | УБ        |

### 3. Өгөгдлийн шинжилгээ


#### 3.1 Олон нийтийн оролцоог хангасан талаарх баримт бичиг

22 тайлангийн 14 нь ИНХ-ын тогтоол, хурлын тэмдэглэл, 7 нь ИНХ-ын тэргүүлэгчдийн хурлын тогтоол, хурлын тэмдэглэл, 1 нь ИТХ-ын тогтоол, тэмдэглэлийг хавсаргасан байна.

ИНХ-ын Тэргүүлэгчдийн тогтоол хавсаргасан 5 тайлан Улаанбаатар хотод, 2 нь орон нутагт байршилтай байна.

Нийт 14 ИНХ-ын тогтоолын 9 нь “Үйл ажиллагааг дэмжих тухай”, “Тайланг дэмжих тухай” гэсэн гарчигтай байна. Харин бусад 5 тогтоолын хувьд доорх байдлаар санал өгөх, уламжлах утгаар гарчигласан байна.


22 тайлангийн олон нийтийн оролцоог хангасан талаарх баримт бичиг



Үнэлгээг хэлэлцсэн тухай  
Санал уламжлах тухай  
Тайланд санал өгөх тухай

Гэхдээ тогтоолын гол заалт нь төслийн үйл ажиллагаа эсвэл үнэлгээний тайланг дэмжих утгатай байна /Жишээ 1/.

### Жишээ 1. Үнэлгээг хэлэлцэж дэмжсэн тогтоол



Үнэлгээг хэлэлцсэн тухай тогтоолын гарчиг

Дэмжих тухай заалт


### 3.2 ИНХ-ын тэмдэглэлийн хэмжээ, бүтэц, агуулга

ИНХ-ын тэмдэглэл дунджаар 2 хуудас, хамгийн багадаа 1 хуудас хамгийн олон нь 4 хуудас байна.

Ихэнх тэмдэглэлд дараах асуудлуудыг товч байдлаар тусгаж байна. Үүнд:

- Хурал болсон огноо
- Хурал болсон газрын нэр
- Хурал эхэлсэн цаг
- Хуралд оролцсон иргэдийн тоо эсвэл хувь
- Баг, сумын удирдлагаас оролцсон хүмүүс
- Танилцуулга хийсэн тухай товч тэмдэглэл
- Асуулт, хариулт, саналын товч тэмдэглэл

ИНХ-ын хуралдааны тэмдэглэлийн хуудасны тоо



- Санал хураалт явуулж дэмжсэн хувь
- Тэмдэглэл хөтөлсөн болон танилцсан хүний нэр, албан тушаал

Зарим тэмдэглэлд хуралдаан эхэлсэн, дууссан цагийг тэмдэглэсэн байна. Үүнээс үзэхэд тайлангийн хэлэлцүүлэгт дунджаар 1-2 цаг зарцуулсан байна.

ИНХ-ын ирцийг хуралдааны тэмдэглэлд оролцсон иргэдийн тоогоор эсвэл нийт өрхийн хэчнээн хувь оролцсныг дурдсан байна. Улаанбаатар хотын Налайх дүүрэгт байршилтай 2 төслийн хэлэлцүүлэгт 31 болон 41 иргэн оролцсон бол Сонгинохайрхан дүүргийн 19-р хорооны ИНХ-д 10 иргэн л оролцсон байна.

Багийн ИНХ-ын ирцийг тоогоор илэрхийлсэн 6 тэмдэглэл байсан. Үүнд хамгийн олон нь 137 иргэн, хамгийн цөөн нь 24 иргэн оролцсон хуралдаан байна. Нийт 3 тэмдэглэлд багийн өрхийн төлөөллийн 75-95 хувь оролцсон гэж тэмдэглэсэн байна. Хуралд оролцогчдын нэр, гарын үсэг бүхий баримт хавсаргасан 3 тэмдэглэл л байна /Жишээ 2/.


### Жишээ 2. Хуралд оролцсон иргэдийн мэдээлэл

Хуралдаант ХХБомсаний "Баян-Уулс" мөнгө хэлбэрт металлны ордыг ашиглах төслийн талаар "Донгод аймгийн Чойбалсан сумын Энгэрзанд багийн иргэдийн санал хураалт"

| №  | Овог нэр   | Регистрийн дугаар | Санал хураалт | Энгэрзанд баг |
|----|------------|-------------------|---------------|---------------|
| 1  | Х.О.С.С.С. | № 8010.5039       | Дамжсан баг   | Х.О.С.С.С.    |
| 2  | Х.О.С.С.С. | № 83033164        | Дамжсан баг   | Х.О.С.С.С.    |
| 3  | Х.О.С.С.С. | № 91092919        | Дамжсан баг   | Х.О.С.С.С.    |
| 4  | Х.О.С.С.С. | № 91092919        | Дамжсан баг   | Х.О.С.С.С.    |
| 5  | Х.О.С.С.С. | № 82001276        | Дамжсан баг   | Х.О.С.С.С.    |
| 6  | Х.О.С.С.С. | № 91121866        | Дамжсан баг   | Х.О.С.С.С.    |
| 7  | Х.О.С.С.С. | № 95051624        | Дамжсан баг   | Х.О.С.С.С.    |
| 8  | Х.О.С.С.С. | № 90180563        | Дамжсан баг   | Х.О.С.С.С.    |
| 9  | Х.О.С.С.С. | № 92010707        | Дамжсан баг   | Х.О.С.С.С.    |
| 10 | Х.О.С.С.С. | № 89051478        | Дамжсан баг   | Х.О.С.С.С.    |
| 11 | Х.О.С.С.С. | № 81011874        | Дамжсан баг   | Х.О.С.С.С.    |
| 12 | Х.О.С.С.С. | № 90061880        | Дамжсан баг   | Х.О.С.С.С.    |
| 13 | Х.О.С.С.С. | № 66111774        | Дамжсан баг   | Х.О.С.С.С.    |
| 14 | Х.О.С.С.С. | № 95011320        | Дамжсан баг   | Х.О.С.С.С.    |
| 15 | Х.О.С.С.С. | № 96131124        | Дамжсан баг   | Х.О.С.С.С.    |
| 16 | Х.О.С.С.С. | № 95011320        | Дамжсан баг   | Х.О.С.С.С.    |
| 17 | Х.О.С.С.С. | № 95011320        | Дамжсан баг   | Х.О.С.С.С.    |
| 18 | Х.О.С.С.С. | № 65010171        | Дамжсан баг   | Х.О.С.С.С.    |
| 19 | Х.О.С.С.С. | № 95011320        | Дамжсан баг   | Х.О.С.С.С.    |
| 20 | Х.О.С.С.С. | № 95011320        | Дамжсан баг   | Х.О.С.С.С.    |
| 21 | Х.О.С.С.С. | № 80091364        | Дамжсан баг   | Х.О.С.С.С.    |
| 22 | Х.О.С.С.С. | № 87010165        | Дамжсан баг   | Х.О.С.С.С.    |
| 23 | Х.О.С.С.С. | № 82041589        | Дамжсан баг   | Х.О.С.С.С.    |


ИНХ-ын хэлэлцүүлгийн тэмдэглэлд нийт 57 асуулт, санал, нэг тэмдэглэлд дунджаар 3-5 асуулт, санал дурдагдсан байна. Эдгээр саналуудын агуулгыг авч үзэхэд 29.8 хувь нь байгаль орчны холбогдолтой, бусад 71.2 хувь нь төсөл хэрэгжүүлэгчтэй хамтран ажиллах, орон нутгийн иргэдийг ажлын байраар хангах, орон нутгийн хөгжлийн төсөл хэрэгжүүлэх талаарх асуулт, саналууд байна. Бусад асуудлын хүрээнд төсөл хэрэгжүүлэгч иргэдэд тайлан, мэдээлэл тогтмол танилцуулж байх асуулт, санал орсныг дурдах нь зүйтэй.

ИНХ-ын тэмдэглэлд дурдсан асуулт, саналын агуулга



Ихэнх асуулт, саналууд нь үнэлгээний тайлангийн танилцуулгыг сонсоод лавлаж асууж буй, төслийн талаар ерөнхий мэдээлэл авахыг хүссэн шинж чанартай буюу хурал болохоос өмнө зохих хэмжээний мэдээлэл аваагүй байгааг илтгэж байна. Жишээ нь хурлын тэмдэглэлд дурдсан нийтлэг асуулт, саналуудын дотор үнэлгээ хийх шалтгаан, үнэлгээний мэдээлэлтэй хэзээ, хаанаас танилцаж болох тухай асуусан асуултууд цөөнгүй байна.

## ИНХ дээр нийтлэг гардаг асуулт, саналууд



Төсөл хэрэгжих орон нутгийн иргэд төслийн талаар ямар мэдээлэл, ойлголттой байна вэ гэдгээс хамаарч хэлэлцүүлгийн явц дахь асуулт, хариултын хүрээ, үр дүн ялгаатай байна. Үүнийг дараах жишээнээс харж болно.

Жишээ 3. Газрын тосны хайгуулын төслийн үнэлгээний тайланг хэлэлцсэн 2 багийн ИНХ-аар иргэдийн тавьсан асуулт ба хариулт

**Асуулт №1 М.Эрдэнэхуяг**

Ажил эхлэхийн өмнө ямар байсан ажил дууссаны дараа ямар байх нь вэ гэдэг асуудлыг энэ тайланг тусгасан байна гэж ойлгож болох уу

**Хариулт №1 Л.Эрдэнэсайхан**

Тэгж ойлгож болно. Бид талбайн байгаль орчны төлөв байдал үнэлгээ хийсэн. Цаашид байгаль орчны менежментийн төлөвлөгөөг жил бүр батлуулахдаа үнэлгээнд тусгагдсан ажлуудыг төсөл хэрэгжүүлэгч компани хийж ёстой.

**Асуулт №2 Ц.Мишигдорж**

Мөн нь манайд Газрын тос хайгуул хийхэд хүнд давцан машин яаж хөрс их эвдэж байсан. Гөвийн хөрс их сийрэг болохоор маш амархан сийрэгжиж бүргнэ үүсдэг. Тэр талаар арга хэмжээг яаж авах вэ.

**Хариулт №2 Л.Эрдэнэсайхан**

Хайгуул хийх гэж буй компани ажлаа эхлэхийн өмнө орон нутагтаа ирж ажлаа бүрэн танилцуулаарай. Жишээ нь хягуур ямар газраар явах, хэд хоног ажиллах гэх мэт мэдээллийг орон нутагтаа танилцуулдаг энэ асуудлаа хамтраал шийдвэрлэж явах нь зөв. Үүнийг тайлангийн зөвлөмж дээр нэмж тусгах болшоо.

**Асуулт №2 иргэн Алтанцацрал**

Газрын тосны хайгуул хийж эхэлсэнээр манай газрыг гадаадуудад өгч байна гэсэн үг мөн үү.

**Хариулт №2 Л.Эрдэнэсайхан**

Та бүхэн тэгж ойлгож болохгүйээ. Танай сумын энэ хэсэг газар нутагт газрын тос байгаа эсэхийг судлуулах зорилгоор МУ-ын засаг төрөөс 4 жилийн хугацаатай Хятадын компанитай гэрээ байгуулсан юмаа. Хэзээ ч энэ нутаг дэвсгэрийг гадны хүмүүст өгөхгүй. Тос байгаа эсэхийг тэдний хөрөнгөөр судлуулаад болно. Энэ хугацаанд харин орон нутгаас хяналтаа сайн тавьж ажиллаарай.

**Асуулт №3 иргэн Батсуурь**

Газрын тос хайхад машин явна гэж байна. Тэгэхээр хөрс эвдрэнэ. Иймээс газар дээгүүр явж хайгуул хиймэргүй байна.

**Хариулт №3 Танан**

Таны асуулт хүнд асуулт байна. Бид хайгуул хийхийн тулд газраар явахгүй бол болохгүйээ. Харин дараа нь нөхөн сэргээлтэй сайн хийнэ.

### 3.3 ИНХ-ын Тэргүүлэгчдын хурлын тэмдэглэлийн хэмжээ, бүтэц, агуулга

ИНХ-ын Тэргүүлэгчдийн хурлын тэмдэглэл дунджаар 2 хуудас, хамгийн багадаа 1 хуудас хамгийн олон нь 3 хуудас байна. Ирцийн хувьд 5 хүний бүрэлдэхүүнтэй



байна. Нэг тохиолдолд тодорхой шалтгааны улмаас зөвхөн 3 тэргүүлэгчийн ирцтэй хурал болж тогтоол гаргасан байна.

ИНХ-ын Тэргүүлэгчдийн хурлын тэмдэглэлд дурдсан асуулт, саналын агуулга




ИНХ-ын хуралдаантай харьцуулахад Тэргүүлэгчдийн хурлаар байгаль орчны холбогдолтой асуудлууд бага, орон нутгийн хөгжил, ажлын байртай холбоотой асуулт, саналууд олон гарсан байна.

Улаанбаатар хотын хорооны ИНХ-ын Тэргүүлэгчдийн хурлын ерөнхий өнгө аяс нь төсөл хэрэгжүүлэгчийн орон нутагт ажлын байр нэмэгдүүлж байгаа үйл ажиллагааг дэмжсэн, хамтран ажиллах асуудалд анхаарсан байна. Түүнчлэн, хэлэлцүүлэгт зөвхөн төсөл хэрэгжүүлэгч оролцсон тохиолдол нийтлэг байна.

### 3.4 ИНХ-аар хэлэлцүүлсэн хугацаа

10 тайлан буюу нийт 22 тайлангийн 45 хувь нь Ерөнхий үнэлгээний дүгнэлт /ЕҮД/ батлагдсанаас хойш 1 сарын дотор ИНХ-аар хэлэлцүүлсэн байна. 5 тайланг 2-3 сарын дотор, 4 тайланг 4 сар болон түүнээс дээш хугацаанд ИНХ-аар хэлэлцүүлсэн байна.



Харин 3 тайланг Ерөнхий үнэлгээ дүгнэлт гарахаас өмнө буюу БОННУ хийж эхлэхээс өмнө хэлэлцүүлсэн байгаа нь анхаарал татаж байна. Эдгээр нь хууль, журамд заасан үнэлгээний тайланг боловсруулж дууссаны дараа ИНХ-аар хэлэлцүүлэх шаардлагыг хэрэгжүүлдэггүй жишээг харуулж байна. 3 тайлан нь бүгд үйлдвэрлэлийн шинэ төслүүдийн үнэлгээ, хоёр нь Улаанбаатар хотод, нэг нь Дундговь аймагт байршилтай байна. Нэг үнэлгээний тайлан нь Ерөнхий үнэлгээ дүгнэлтээр 3 сарын хугацаа өгсөн боловч 1 сарын дотор хийгдэж батлагдсан бол бусад хоёрын хувьд дүгнэлтэд заасан хугацаанаас 1-3 сарын өмнө дуусгаж батлуулсан байна. Улаанбаатар хотод байршилтай хоёр төсөл ИНХ-ын Тэргүүлэгчдийн тогтоол, ИТХ-ын тогтоолыг хавсаргасан бол Дундговь аймгийнх багийн ИНХ-ын тогтоолыг хавсаргасан байна.

Нийт тайлангийн 45 хувь нь ЕҮД гарснаас хойш маш богино хугацаанд буюу 1 сарын дотор ИНХ-аар хэлэлцүүлсэн нь маш богино хугацаанд БОННУ хийж, тайланг боловсруулсан эсвэл тайлан биш ерөнхий мэдээлэл танилцуулж, санал авсан гэдэг дүгнэлтэд хүргэж байна. Дээрх 10 төслүүдийн зөвхөн хоёр нь л нэмэлт тодотгол бөгөөд ЕҮД-д 1-2 сарын хугацаанд БОННУ хийхээр заасан байна. Үлдсэн 8 төслийн БОННУ хийх хугацааг дунджаар 4-6 сараар ЕҮД-д заасан боловч дунджаар 2-3 сарын дотор БОННУ нь батлагдсан байна.

### 1 сарын дотор ИНХ-аар хэлэлцүүлсэн 10 үнэлгээний тайлангийн



ЕҮД гарснаас 4 болон түүнээс олон сарын дараа ИНХ-ээр хэлэлцүүлсэн 4 тайлан бүгд орон нутагт байршилтай төслийнх, 3 нь уул уурхай, 1 нь үйлдвэрлэлийн чиглэлийнх байна. Үүнээс Дорнод аймагт байршилтай “Алт агуулсан мөнгө-холимог металлын орд ашиглах” төслийн ЕҮД анх 2014 онд 14 сарын хугацаатай батлагдсан бол ИНХ-аар хэлэлцүүлсэн тогтоол нь 2017 онд гарсан байна. Ямар шалтгаанаас болж ЕҮД-ээс хойш 36 сарын дараа ИНХ-аар хэлэлцүүлснийг зөвхөн энэ өгөгдлөөс тодорхойлох боломжгүй юм.

#### 4. Хууль, журмын хэрэгжилт

##### 4.1 БОННУ хийх явцын оролцоо

Дүн шинжилгээ хийсэн 22 тайланд холбогдох ИНХ-ын хэлэлцүүлгийн тэмдэглэл, тогтоолд хууль, журамд заасан үнэлгээ хийх явцад иргэдэд шаардлагатай мэдээлэл өгсөн, танилцуулга хийсэн, санал авч, хэлэлцүүлэг зохион байгуулсан эсэх талаар огт дурдаагүй байна. Харин иргэд төслийн болон БОННУ-ний талаар урьдчилсан мэдээлэл авалгүйгээр хуралд оролцсон болохыг илтгэж буй асуулт, саналууд байна /Жишээ 4/. Үүнд:

- Төслийн үйл ажиллагааны тухай ерөнхий мэдээлэл асуух
- Төслийн байгаль орчны нөлөөллийн талаар ерөнхий асуулт асуух
- Үнэлгээний тайлангийн төслийг хаанаас уншиж болох тухай асуух

- Өмнөх жилүүдийн менежментийн төлөвлөгөөний тайланг танилцуулахыг хүсэх

Жишээ 4. ИНХ-ын өмнөх мэдээллийн хүртээмжгүй байдал

**Малчин О.Эрдэнэбаатар:** Ийм үнэлгээ хийлгэсний ач холбогдол юу вэ, хэний санаачлагаар хийлгэдэг вэ?

**Б.Очмаа:** “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулийн дагуу аливаа үйл ажиллагаа явуулж байгаа иргэн аж ахуйн нэгжүүд энэ үнэлгээг заавал хийлгэх шаардлагатай байдаг. Захиалагчийн хүсэлтээр мэргэжлийн байгууллага хийдэг. Энэ тайлангийн дагуу танай сум төмрийн үйлдвэрийн үйл ажиллагаанд хяналт тавиад явах боломжтой. Мөн та бүхэн мэдээлэл авах боломжтой. Төмрийн үйлдвэрийн захиргаа жил бүрийн эцэст төлөвлөгөөнийхөө биелэлтийг тайлагнаж, дараа жилийнхээ төлөвлөгөөг батлуулсны үндсэн дээр үйл ажиллагаа явуулдаг.

**Иргэн Б.Дондогсүрэн:** Ийм тайлангийн хэлэлцүүлэгт анх удаа оролцож байна. Сайхан баримт бичиг байдаг юм байна. Төмрийн үйлдвэрийн зүгээс манай суманд нилээд сайн дэмжлэг үзүүлэгийг мэднэ. Тайлан байгаль орчны ямаар батлагдах ёстой юм шиг байна. Дэмжиж байна. Харин батлагдсаны дараа суманд өгөх хэрэгтэй.

**Б.Очмаа:** Тайланг хуулийн дагуу орон нутагт хүргүүлэх ёстой. Тайлангаа БОАЖЯ-аар батлуулсны дараа бид зохих журмын дагуу та бүхэнд хүргүүлнэ гэлээ.

4.2 ИНХ-ын саналын томъёолол

Дүн шинжилгээ хийсэн нийт ИНХ, ИНХ-ын Тэргүүлэгчдийн, ИТХ-ын тогтоолын үндсэн заалт нь тайлан эсвэл төслийн үйл ажиллагааг дэмжсэн утгатай байна. Нийт 22 тогтоолоос зөвхөн 2 л тогтоолд иргэдийн гаргасан саналуудыг тоймлон дурдаж тайлан, төлөвлөгөөнд тусгахыг уламжилсан байна. Өөрөөр хэлбэл ИНХ, ИТХ-ын тогтоол нь дэмжсэн саналыг илэрхийлэх зорилготой гэдэг нийтлэг жишиг тогтсон байна.

Хүснэгт 2. Хурлын тогтоолд нэгдсэн санал илэрхийлсэн байдал

|     | Тодорхой саналууд тусгасан эсэх | Үндсэн дэмжсэн заалтын бичилт   |
|-----|---------------------------------|---|
| 1   | Тийм                            | ...дэмжсэнд тооцсугай.  |
| 2.  | Үгүй                            | ...багийн иргэдийн саналаар дэмжсэн болно.  |
| 3.  | Үгүй                            | ...хуралд оролцсон иргэдийн 84 хувь дэмжсэнийг БОАЖЯ-нд уламжилсугай.   |
| 4.  | Үгүй                            | ...ээрэг үнэлгээ өгсөн тул үйл ажиллагааг дэмжсүгэй.  |
| 5.  | Үгүй                            | ...тайлангуудыг дэмжсүгэй.  |
| 6.  | Үгүй                            | ...тайланг дэмжсүгэй.   |
| 7.  | Үгүй                            | ...тайланг дэмжсүгэй.   |
| 8.  | Үгүй                            | ...олонхийн саналаар дэмжсэнийг баталсугай.   |
| 9.  | Үгүй                            | ...тайланг дэмжсүгэй.   |
| 10. | Үгүй                            | ...үнэлгээ хийлгэх, олборлолт явуулахад татгалзах зүйлгүй гэж үзсүгэй.  |
| 11. |                                 | ...компаниудын үйл ажиллагааг дэмжсүгэй.  |
| 12. | Үгүй                            | ...ажлын тайланг дэмжсүгэй.   |
| 13. | Үгүй                            | ...үнэлгээний компанийн саналыг дэмжсүгэй.  |
| 14. | Үгүй                            | ...төслийн үйл ажиллагааг дэмжиж уламжлав.  |
| 15. | Үгүй                            | ...БОННУ гаргахад татгалзах зүйлгүй, хуралд оролцсон иргэдийн 80 хувь нь эерэг үнэлгээ өгсөн тул үйл ажиллагааг дэмжсүгэй |
| 16. | Үгүй                            | ...үнэлгээний тайланг дэмжсүгэй.  |
| 17. | Үгүй                            | ...хэрэгжүүлэхэд татгалзах зүйлгүй  |

|     |             |   |
|-----|-------------|---|
| 18. | Үгүй        | ...тайланг хэлэлцэн дэмжив                                      |
| 19. | <b>Тийм</b> | ...100 хувийн саналаар дэмжсэн тул Дүүргийн ИТХ-д уламжилсугай. |
| 20. | Үгүй        | ...тайланг дэмжсүгэй.   |
| 21. | Үгүй        | ...100 хувийн саналаар БОННУ хийхийг дэмжив.                    |
| 22. | Үгүй        | ...тайланг дэмжсүгэй.   |

Ихэнх тогтоолд төсөл хэрэгжүүлэгчид хандан иргэдийн саналыг харгалзан үзэх, орон нутагтай хамтран ажиллахыг уламжилсан, үүрэг болгосон заалтууд орсон байна. Түүнчлэн, төслийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг баг, хорооны засаг даргад үүрэг болгосон заалт нийтлэг байна.

Иргэдийн саналыг нэгтгэж оруулсан 2 тогтоолыг авч үзэхэд байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл, түүнийг бууруулах талаарх тодорхой санал цөөн байна /Жишээ 5/.

#### Жишээ 5. Тогтоолд иргэдийн саналыг нэгтгэж тусгасан тохиолдол

2."Саян Стийл" ххк нь иргэдийн тавьсан саналын дагуу доорхи дурьдсанаар тогтоосугай

- а. Булаг хаших
- б. Иргэдээс ирсэн санал гомдлыг арилгах

3.Иргэдийн тусгасан саналын дагуу ажиллахыг "Саян Стийл" ххк-д уламжилсугай

4.Тогтоолыг холбогдох байгууллага ба багийн иргэдэд мэдээлж ажиллахыг багийн Засаг дарга /О.Баттогтох/-д даалгасугай.

5.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Багийн Иргэдийн Нийтийн Хурлын Тэргүүлэгчдэд үүрэг болгосугай.

тайлантай танилцлаа. Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний асуудлыг тусгах саналтай байна.

1. Хариуцлагатай уул уурхай зарчмыг баримтлан ажиллах
2. Ажлын байрны саналаа сумын иргэдэд ил тод тавих
3. Байгаль орчин хамгаалах ажилд нутгийн иргэдтэй хамтран ажиллах санал хүсэлтийг харгалзан үзэж байх
4. 2-рбагийн болон тус сумын хүүхэд залуучуудыг сурч боловсроход дэмжлэг үзүүлэх
5. Бэлчээрийг сайжруулах чиглэлээр хамтарч ажиллах /худаг, ус/
6. Нөхөн сэргээлтийг маш сайн хийх

Жи Пи Эм ХХК –ний Нүүрс олборлон борлуулах , Нүүрснээс Нийлэг Байгалийн Хий үйлдвэрлэх Үйлдвэр төслийг хэрэгжүүлэхэд татгалзах зүйлгүй .

#### 4.3 ИНХ-ын тогтоолын хуулийн үндэслэл

22 тогтоолын 77 хувь холбогдох хууль, журмын заалтуудыг үндэслэн шийдвэр гаргаж буйг дурдсан байна. ЗЗНДН-ийн тухай хуулийн 17.1.8, 17.1.10, БОНБҮ-ний тухай хуулийн 8.4.8, 18.4 дэх заалтуудыг хамгийн их дурдсан байна.

**Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн тухай хууль**

17 дугаар зүйл. Баг, хорооны Хурлын бүрэн эрх  
17.1.8.иргэдийн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагаас тухайн нутаг дэвсгэрийн байгалийн тодорхой төрлийн баялгийг хамгаалах, зүй зохистой ашиглах, эзэмших тухай хүсэлтийг хэлэлцэж саналаа сум, дүүргийн Хуралд уламжлах;  
17.1.10.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.;

**Байгаль орчин нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль**

8.4.8 “төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн захиргаа, төслийн нөлөөлөлд өртөх нутгийн иргэдийн нийтийн хурлын санал, тэмдэглэл”  
18.4. төслийн нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийж байгаа хуулийн этгээд тайлан боловсруулах явцдаа төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн захиргаа, төслийн нөлөөлөлд өртөх нутгийн иргэд, оршин суугчдаас албан ёсоор санал авч, хэлэлцүүлэг зохион байгуулна.

Түүнчлэн ЗЗНДН-ийн тухай хуулийн 25.1. буюу “Хурал хэлэлцсэн асуудлаар тогтоол гаргах бөгөөд түүнийг тухайн Хурлын хуралдаанд оролцсон төлөөлөгчдийн болон баг, хорооны Хурлын хуралдаанд оролцсон иргэдийн олонхын саналаар тус тус батална”, 23.2. буюу “Аймаг, нийслэл, сум, дүүргийн Хурлын ээлжит хуралдааныг жилд 2-оос доошгүй удаа, баг, хорооны Хурлын хуралдааныг жилд 3-аас доошгүй удаа тус тус хуралдуулна”, БОНБҮ-ний тухай хуулийн 10.5. буюу “Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг төсөл хэрэгжүүлэгч, үнэлгээ хийсэн мэргэжлийн байгууллага хамтран төслийн нөлөөлөлд өртөх орон нутгийн оршин суугчдад танилцуулах ажлыг зохион байгуулна” гэдэг заалтуудыг зарим тогтоолд дурдсан байна.

Зөвхөн 1 тогтоолд Засгийн газрын 2013 оны 374-р тогтоол буюу “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журам”-ыг дурдсан байна. Харин БОНБҮ-нд олон нийтийн оролцоог хангах журмыг дурдсан тогтоол байхгүй байна.

#### 4.4 Албан хэрэг хөтлөлт

Хурлын тогтоолууд нь дараах үндсэн мэдээлэл бүхий харьцангуй нийтлэг загвараар бичигдсэн байна. Үүнд

- Огноо, дугаар, байршил
- Тогтоолын гарчиг
- Холбогдох хуулийн заалтууд
- БОАЖЯ-нд хандсан тайланг хэлэлцэж дэмжсэн тухай заалт
- Төсөл хэрэгжүүлэгчид хандсан хамтран ажиллах тухай заалт
- Багийн удирдлагад хандсан хяналт тавьж ажиллах тухай заалт
- Хурлын дарга буюу эрх бүхий албан тушаалтны гарын үсэг

Гэхдээ дараах зөрчлүүд зарим тогтоолд илэрч байна. Үүнд:

- ИНХ-ын Тэргүүлэгчдийн хурал хуралдсан боловч ИНХ-ын тогтоол гаргасан.
- Тогтоолын гарчиг байхгүй болон ерөнхий
- Хуулийн үндэслэл дурдаагүй
- Үнэлгээ эрхлэгчийн тухай мэдээлэл дутуу

Үнэлгээний тайлангийн хэлэлцүүлгийг хэрхэн зохион байгуулсан мэдээлэл /ээлжит ба ээлжит бус хурал, зар мэдээ, ирц/ оруулсан тохиолдол алга байна.

Хуралдааны тэмдэглэлийг “Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”-ын дагуу зохих хэмжээнд хөтөлсөн тэмдэглэл 14 буюу 63.6 хувьтай байна.

22 тэмдэглэлээс 16 нь хөтөлсөн хүний гарын үсгээр баталгаажсан, 8 нь ИНХ-ын удирдлага давхар хянаж, баталгаажуулсан байна.

Дараах зөрчлүүд зарим тэмдэглэлд илэрч байна. Үүнд:

- Ээлжит, ээлжит бус хуралдаан эсэх нь тодорхойгүй
- 1-2 цаг үргэлжилсэн хуралдаан гэж тэмдэглэсэн боловч маш товч, хураангуй тэмдэглэл хийсэн
- Тэмдэглэлийг хэн хөтөлсөн, хянасан нь тодорхойгүй
- Хурлын ирц, нийт өрхөд эзлэх хувь зэргийг нотлох баримт, харьцуулах тоогүйгээр бичсэн

## 5. Дүгнэлт, зөвлөмж

БОНБУ-ний тухай хууль, холбогдох журмаар БОННУ хийж, тайлан боловсруулах явцад иргэдээс санал авах, улмаар тайлангийн төслийг ИНХ-аар хэлэлцүүлж санал авах шаардлага тавигддаг. Энэ шаардлагын хэрэгжилтийг нотлох баримт болох ИНХ-ын тогтоол, тэмдэглэлд ИНХ-аар хэлэлцүүлэхээс өмнөх мэдээлэл өгөх, танилцуулга хийх, санал авах үй ажиллагааны талаар огт дурдалгүй зөвхөн ИНХ-ын хэлэлцүүлгийн явц, үр дүнг тусгасан байна.

ИНХ-ын тэмдэглэл дунджаар 2 хуудас, хамгийн багадаа 1 хуудас хамгийн олон нь 4 хуудас байна. ИНХ-ын хэлэлцүүлгийн тэмдэглэлд нийт 57 асуулт, санал, нэг тэмдэглэлд дунджаар 3-5 асуулт, санал дурдагдсан байна. Эдгээр саналуудын агуулгыг авч үзэхэд 29.8 хувь нь байгаль орчны холбогдолтой, бусад 71.2 хувь нь төсөл хэрэгжүүлэгчтэй хамтран ажиллах, орон нутгийн иргэдийг ажлын байраар хангах, орон нутгийн хөгжлийн төсөл хэрэгжүүлэх талаарх асуулт, саналууд байна. Ихэнх асуулт, саналууд нь үнэлгээний тайлангийн танилцуулгыг сонсоод лавлаж асууж буй, төслийн талаар ерөнхий мэдээлэл авахыг хүссэн шинж чанартай буюу хурал болохоос өмнө зохих хэмжээний мэдээлэл аваагүй байгааг илтгэж байна.

Дүн шинжилгээ хийсэн 22 тайлангийн 14 нь ИНХ-ын тогтоол, хурлын тэмдэглэл, 7 нь ИНХ-ын тэргүүлэгчдийн хурлын тогтоол, хурлын тэмдэглэл, 1 нь ИТХ-ын тогтоол, тэмдэглэлийг хавсаргасан байгаа нь хууль адил тэгш хэрэгжихгүй байгааг харуулж байна. ИНХ-ын Тэргүүлэгчдийн тогтоол хавсаргасан 5 тайлан Улаанбаатар хотод, 2 нь орон нутагт байршилтай байна.

Дүн шинжилгээ хийсэн нийт ИНХ, ИНХ-ын Тэргүүлэгчдийн, ИТХ-ын тогтоолын гарчиг эсвэл үндсэн заалт нь тайлан эсвэл төслийн үйл ажиллагааг дэмжсэн утгатай байна. Нийт 22 тогтоолоос зөвхөн 2 л тогтоолд иргэдийн гаргасан саналуудыг тоймлон дурдаж тайлан, төлөвлөгөөнд тусгахыг уламжилсан байна. Өөрөөр хэлбэл ИНХ, ИТХ-ын тогтоол нь дэмжсэн саналыг илэрхийлэх зорилготой гэдэг нийтлэг жишиг тогтсон байна.

Нийт 22 тайлангийн 45 хувь нь Ерөнхий үнэлгээний дүгнэлт гарснаас хойш маш богино хугацаанд буюу 1 сарын дотор ИНХ-аар хэлэлцүүлсэн нь маш богино хугацаанд БОННУ хийж, тайланг боловсруулсан эсвэл тайлан биш ерөнхий мэдээлэл танилцуулж, санал авсан гэдэг дүгнэлтэд хүргэж байна. 3 тайлан нь Ерөнхий үнэлгээний дүгнэлт гарахаас өмнө ИНХ-аар хэлэлцүүлсэн тогтоолыг тусгасан байгаа нь ИНХ-ын хэлэлцүүлэг хууль, журамд зааснаар хэрэгжихгүй, зөвхөн дэмжсэн тогтоол гаргуулахад анхаар байгаа хандлагыг харуулж байна.

Дээрх дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг БОАЖЯ-нд зөвлөж байна. Үүнд:

- Хууль, журамд заасан ИНХ-аар үнэлгээний тайланг боловсруулж дууссаны дараа хэлэлцүүлэх шаардлагыг ИНХ-ын тогтоол, тэмдэглэлд тодорхой тусгах, түүний нотлох баримт хавсаргах
- Хууль, журамд заасан БОННУ хийж, тайлан боловсруулах явцдаа буюу тайлангийн төслийг ИНХ-аар хэлэлцүүлэхээс өмнө оролцоог хангасан талаарх мэдээлэл, нотлох баримтыг хурлын тогтоол, тэмдэглэлд тусгах, түүний нотлох баримтыг хавсаргах
- Тайлангийн төслийг ИНХ-ын Тэргүүлэгчдээр хэлэлцүүлэх эрхзүйн үндэслэл, холбогдох зохицуулалтыг тодорхой болгох
- ИНХ-ын хуралдаанаар тайлангийн төслийг хэлэлцсэн тогтоол, тэмдэглэл, нотлох баримтын жишиг загварыг “Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”-д нийцүүлэн батлах, үүнд дэмжсэн, зөвшөөрсөн утга агуулга биш тодорхой саналуудыг хэрхэн уламжлах талаар тодорхой тусгах
- БОННУ-нд олон нийтийн оролцоог хангах журамд ИНХ-ын хэлэлцүүлэг зохион байгуулах, түүний үр дүнг хэрхэн тайлагнах нарийвчилсан зохицуулалт оруулах

Australia Mongolia Extractives Program  
2A Temple View Residence  
Suhbaatar District-1  
Ulaanbaatar  
Mongolia  
T: +976 7000 8595

Энэхүү тайланг Австрали Улсын Засгийн газар, Австралийн Гадаад хэрэг, худалдааны яам санхүүжүүлсэн боловч тус тайланд тусгасан үзэл санаа нь Австрали Улсын Засгийн газрын бус гагцхүү зохиогчийн үзэл бодол болно. Мөн түүнчлэн энэ тайланд тусгасан үзэл баримтлалыг Австрали Улсын Засгийн газар дэмжиж байгаа гэж ойлгож болохгүй. Тус улсын Засгийн газар энэ тайланд багтсан мэдээллийн бүрэн болон үнэн зөв эсэхийг батлахгүй. Энэхүү хэвлэлд орсон тоо баримт, мэдээ материал алдаа мадагтай, дутуу хагас байж болзошгүй бөгөөд түүнээс үүдэн гарах аливаа хохиролд Австрали Улсын Засгийн газар, хариуцлагатай албан тушаалтан, ажилтан, албан хаагч, гэрээт ажилчид ямар нэг хариуцлага хүлээхгүй болно

Энэхүү тайлан нь ерөнхий мэдээлэл өгөх зорилготой. Аливаа шийдвэр гаргахаас өмнө тайланг уншиж, хэрэглэж буй тал мэдээллийн анхдагч эх сурвалжтай холбогдон, мэдээ баримтаа лавшруулан шалгаж, бие даасан судалгаа хийн, зөвлөгөө авах нь зүйтэй